


КОРОНАГИЙН ТУН



2020 он



КОРОНАГИЙН ТУН

Энэхүү нийтлэлийг Фридрих-Эбертийн сангаас орчуулан гаргав.

Орчуулсан: Ч. Оюунгэрэл
ФЭС-гийн хөтөлбөрийн менежер

Редактор: Д.Нарантуяа
Эхийг бэлтгэсэн: Ё.Батболд

©ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас эрхлэн гаргав. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

КОРОНАГИЙН ТУН

2020 он



КОРОНАГИЙН ТУН I

Эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүд дэлхий дахинд ба хямралын хохирлыг арилгах зардалын санхүүжилт

Филип Каупперт

Коронагийн цар тахлын тархалтыг хөл хорио тогтоох замаар намжаах, хязгаарлах бодлогын төгсгөлд дэлхий даяараа эдийн засгаа дахин хэрхэн сэргээх вэ? хямралын хохирлыг арилгахад шаардагдах зардлыг хаанаас санхүүжүүлэх вэ? гэдэг асуултын хариултыг сандарч тэвдэн хайж эхлэх болно. Эдийн засгийн бүх таамаглалууд бүгдээрээ эдийн засаг өмөрч цөмөрсөн мэт нурах болно, 2020 он эдийн засгийн гүнзгий хямралын жил байсан гэдгээрээ түүхэнд бичигдэх болно гэдгийг хэлээд байна. Дэлхийн I ба II дайны дараагаар эдийн засгийн бодлогын тулгын чулууг тавьж байх үеийнхтэй харьцуулах хэмжээний эдийн засгийн сүйрэл болоод байна гэдэг санаагаа илэрхийлэхийн тулд гүйцэтгэх засаглалынхан “сэргээн босголт” гэдэг үгийг хэлсэн үг, илтгэлдээ хэрэглэж хүмүүсийн ой тойнд суулгасаар байна. Олон орон нэн тэргүүнд хөдөлмөр эрхлэлтийн бодлого дээрээ төвлөрч албан хаагчид, компаниудыг гараас нь хөтлөн хямралыг гэтэлгэхийн тулд богиносгосон цагийн хөдөлмөр, татварын хөнгөлөлт зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Үүнээс гадна нийгмийн хамгаалал, халамж ба тэтгэмжийн мөнгөний хэмжээг нэмэгдүүлэх, төрлийг олшруулах замаар эрэлтийг тогтворжуулж ингэхдээ юуны өмнө орлого багатай өрхүүдэд дэмжлэг үзүүлэхэд гол анхаарлаа төвлөрүүлж байна. Өнөөг хүртэл төрийн шууд хөрөнгө оруулалтын ихэнхийг дэд бүтцийг сайжруулах, том төслүүдийн санхүүжилтэд зарцуулахаар төлөвлөдөг байсан бол хямралын улмаас төсвийн хөрөнгөөр стратегийн компаниуд, тэргүүлэх салбаруудыг төрийн мэдэлд буцаан

авах зорилт нэмэгдээд байна. Ирэх саруудад нийгэм-экологийн шилжилтийн үзэл санаанд нийцсэн байх ёстой гэдэг утгаараа өргөн хүрээтэй аж үйлдвэрийн бодлогод илүү өндөр шаардлага тавигдах нь.

Европт хямралаас гарах, гэтлэх арга замын талаар олон янзын хэлэлцүүлэг өрнөж байна. Австрийн холбооны улсын ерөнхий сайд Күрц Бүгд Найрамдах Австри улс байгуулагдсаны 75 жилийн ойн арга хэмжээний үеэр хэлсэн үгэндээ дайны дараах “сэргээн босголт”-той харьцуулан эдийн засгийн бодлогын энэ удаагийн хүнд цохилтын онцлог шинжүүдийг тайлбарласан. Нийгмийн баримжаат төр нь олон жилийн туршид шүүмжлэлийн бай болсоор, төр нь өрсөлдөөний шалгуур үзүүлэлтүүдийн дагуу зохион байгуулагдсан хэвээрээ байгаа ч Шведийн засгийн газар тэр ч байтугай нэгэн шинэ “социалдемократ эгшин”-тохиох гэж байгааталаар ярих боллоо. Францын ерөнхийлөгч Макрон “эдийн засгийн том сорилтууд”-ыг шийдвэрлэхийн тулд эдийн засгийн салбарын нэр хүндтэй мэргэжилтнүүдийн комиссыг байгуулж Францын эдийн засгийг өөрчлөн байгуулах урт хугацааны төсөөллийг боловсруулах үүрэг өгөөд байна. Испанийн засгийн эрхийг баригч хоёр нам болох PSOE ба Unidos Podemos намууд их хурлаараа нийгэм-эдийн засгийг сэргээн босгох дунд болон урт хугацааны арга хэмжээнүүдийг боловсруулах комисс байгуулсан.

Хятадын засгийн газар өнөөг хүртэл хямралын талаар олон нийтэд нээлттэй ярилцахаас цааргалсаар байна. 2020 оны



5-р сард хуралдсан ард түмний конгрессоос олон жилийн туршид өсөлтийн хувь хэмжээг албан ёсоор зарлаж ирсэн уламжлалаа эвдэж энэ жил анх удаагаа өсөлтийн зорилтот хувь хэмжээг зарласангүй. Хятадын эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүдийн стратегийн нэгэн чухал тулгуур нь технологи бөгөөд шинэ технологид шаардагдах “шинэ дэд бүтэц” дээр гол анхаарлаа төвлөрүүлж байгаа юм. Одоогоор бүдэг бадаг зураг нь тодроод байгаа хятадын эдийн засгийн сэргэлт АНУ ба Хятад хоорондын худалдааны зөрчилдөөн цаашид яаж өрнөхөөс хүчтэй хамаарах болно. Худалдааны зөрчлийн зэрэгцээ Хятад улс ажилгүйдэл эрс нэмэгдэх, төрийн буюу нийтийн дэд бүтэц, нэн ялангуяа эрүүл мэндийн системийн дэд бүтцийн элэгдэл, хоцрогдлын эсрэг тэмцэж байгаа юм.

АНУ-ын Ерөнхийлөгч Трампд тэмдэгтийн банкаар дамжуулан банкнуудын нөөцийн хуримтлалыг эрс нэмэгдүүлснээр 11-р сард болох ерөнхийлөгчийн сонгуулиас өмнө их хэмжээний мөнгө гаргах, цар тахал тархахаас өмнө өндөр өсөлттэй байсан Америкийн эдийн засгийг дахин сэргээх боломж нээгдэж байгаа юм. АНУ-ын эдийн засгаа сэргээх хөтөлбөр нь ДНБ-нийхээ 14 орчим хувьтай тэнцэж байгаа бол Хятадынх ДНБ-нийхээ 4 хувьтай тэнцэх болов уу? гэсэн таамаглал байна. Ингэснээр коронагийн хямралын дараа эдийн засгаа сэргээх хөтөлбөрүүдэд 2008 онд тохиосон дэлхийн санхүүгийн хямралын дараа хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдээс илүү мөнгө зарцуулагдах нь.

“Европын Холбооны дараагийн үе” хөтөлбөр нь эерэг нөлөө ихтэй, эдийн засгийн бодлогын интеграц буюу нэгдлийг урагшлуулна гэдэг утгаараа анхаарал татахуйц үсрэлт болох юм. Уг хөтөлбөрийн хүрээнд 500 тэрбум еврог гишүүн орнуудад шууд хуваарилах бөгөөд дээрээс нь 250

тэрбум еврогийн зээл олгох тул хөтөлбөрийн нийт дүн 750 тэрбум евро болох юм. Европын комисс ба парламентын хяналтын дор 2021-2024 онд түүхэн дээд хэмжээний хөрөнгө оруулалтыг зорилтот, ирээдүйн хөгжлийн хэтийн чиглэлийг тогтоох салбаруудад оруулах юм. Комиссын бодлогын удирдамж ба европын зөвлөлөөс баталсан 2019-2024 оны хөгжлийн стратегийн хүрээнд дараах 6 тэргүүлэх зорилтыг хангахад хөрөнгө оруулалтыг зарцуулах болно.

- Европын ногоон хэлэлцээр ёсоор европ нь дэлхийн таван тивээс анхны ногоон тив болох юм.
- Дижитал эрин үеийн европ. Технологийн шинэ үеийг хөгжүүлэх замаар идэвхтэй оролцоотой байх.
- Хүмүүсийн тусын тулд үйлчилдэг эдийн засагтай байх. Нийгмийн шударга ёс ба хангалуун чинээлэг амьдрал.
- Өнөөгийн дэлхий дээр илүү хүчирхэг европ байх. Европын дэлхийд тэргүүлэх үүргийг хариуцлагатайгаар бататгах.
- Европын амьдрал, аж байдлыг дэмжих, Иргэдээ, үнэлэмжээ хамгаалах.
- Европын ардчилалд шинэ хүч сэлбэх, Европын ардчиллыг дэмжих, хамгаалах, бэхжүүлэх.



Засгийн газруудын үйл ажиллагааны хувилбарууд-гарааны нөхцөлүүд нь хоорондоо эрс өөр байна.

Олон улсын харьцуулсан судалгаагаар засгийн газруудын хямралын бодлогоо боловсруулах гарааны нөхцөлүүд хоорондоо эрс зөрүүтэй байгаа нь тодорхой харагдаж байна. Капиталист төвийн буюу барууны аж үйлдвэржсэн орнуудын эдийн засагт олон жил үргэлжилсэн бүсээ чангалах-хэмнэлтийн бодлогын дараагаар мөнгөний бодлого эгэн ирж байна. Мөнгөний бодлогоор дамжин төсвийн томоохон хөрөнгө оруулалтуудыг хийх боломжтой болж зах зээлүүдийн хөгжилд төрийн хөндлөнгийн оролцоо буюу улс төрийн оролцоог дахин сайшаадаг боллоо. Тойргийн захын орнууд буюу хөгжиж буй, хөгжлөөр хоцрогдсон орнуудын эдийн засагт эдийн засгаа сэргээх хөтөлбөрүүд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хувилбар маш хязгаарлагдмал байна. Түүхий эдийн үнийн уналт болон ихэнх орнуудын өрийн даац хэтэрснээс болоод эдгээр орнуудад хуучны хамааралт байдал ба хөгжлийн замналаас хараат байдал гүнзгийрлээ. Үүний тодоос тод нэгэн жишээ бол: Африкийн холбооны гишүүн орнууд 4-р сарын сүүлчээр Ковид-19-ын хариуцлагын фонддоо 68.5 сая доллар төвлөрүүлсэн бол африкийн орнуудын улс ардын аж ахуйнууд зөвхөн 2020 оны зээлийн хүүгийн төлбөрт 16 тэрбум доллар төлөх ёстой байгаа юм.

Социалдемократ болон зүүний засгийн газруудын эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүд юуны өмнө нийгмийн хүчин зүйлүүд дээр төвлөрдөг.

- Аргентинд орон сууцны барилгажилт, эрүүл мэндийн систем ба хотжилтын дэд бүтцүүдийг өргөтгөнө.
- Данид нийтийн эзэмшлийн барилга ба

эрчим хүчний хэмнэлтийг сайжруулахад хийх хөрөнгө оруулалтыг дэмжинэ.

- Италид эрчим хүчний хэмнэлтийг нэмэгдүүлэхийн тулд орон сууцны дулаалгыг сайжруулах, мөн орон сууцыг газар хөдлөлтөд тэсвэртэй болгох зардлыг төрөөс бүрэн даана.
- Испанид суурь орлого нэвтрүүлэн бага орлоготой өрхүүдийн нийгмийн баталгааг сайжруулсан бол өргөн хүрээтэй "шинэчлэл-хөрөнгө оруулалтын төлөвлөгөө"-г европын холбооны санхүүжилттэй хослуулан хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

Европын комиссын вебсайт дээр 2019-2024 оны онцлох зорилтуудыг ач холбогдолынх нь дагуу эрэмбэлсэн байгаа: https://ec.europa.eu/info/strategy/priorities-2019-2024_de

Тунисийн засгийн газар зээлдүүлэгчид болон Олон Улсын Валютын Сангийн эсрэг хувьчлалын оронд төрийн өмчийн компаниудын шинэчлэл хийхийн төлөө тэмцэж байна.

Энэ тэмцлийн явцад хэлэлцүүлгийн үеэр хөтөлбөрт тэргүүлэх ач холбогдолтой байгаагүй эрчим хүчний шилжилт, цаг уурын өөрчлөлтийн эсрэг явуулах тэмцэл зэрэг экологийн хүчин зүйлсийн үнэлэмж эрс дээшилсэн байна. Сөрөг хүчний шаардлагууд зарим талаар социалдемократ намууд, үйлдвэрчний эвлэлүүдийнхээс давж байна.

- Эстонид ДНБ-ний нэгээс доошгүй хувийг судалгаа ба хөгжил, мөн байгаль орчинд ээлтэй технологид зарцуулахыг шаардаж байна.



- Францын үйлдвэрчний эвлэлийнхэн тус улсын "эдийн засаг-нийгмийн хөгжлийн загвар"-ыг шинэчлэхийг шаардаж өнөөгийн учир дутагдалтай нийгмийн хэлэлцээрийг шүүмжилж байна. Макроны "цэвэр авто машин" үйлдвэрлэлд тэргүүлэгч орон болох аж үйлдвэрийн төлөвлөгөө зүүний намуудын дэмжлэгийг хүлээж байна.
- Хорват улс аялал жуулчлалын салбартаа дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ дахин аж үйлдвэржилтийн үндэсний стратегия боловсруулж байна.
- Словакт албан хаагчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, жижиг компаниудыг хамгаалахын тулд хөдөлмөр эрхлэлтийн

идэвхтэй бодлого хэрэгжүүлэхийг шаардаж байна.

- Туркт засгийн эрхийг баригч намтай үүссэн зөрчилдөөнийг цахилгаан, ус, хийн үндсэн хангамжийн асуудал яригддаг хот тосгодын төвшинд шийдвэрлэхийг зорьж байна.

Олон социалдемократ намууд, үйлдвэрчний эвлэлүүдэд хямрал ид дундаа орчхоод байгаа энэ үед богино хугацаанд үр дүн нь гарах ёстой хуваарилалтын асуудал, ажлын байрыг яаралтай хамгаалах, тусгай төсвийг санхүүжүүлэх асуудлаас хальж өргөн хүрээтэй, ирээдүйд чиглэсэн эдийн засгийн өөрчлөн байгуулалтын тухай бодлогын асуудал хэлэлцэхэд амаргүй байна.

Хямралын хохирлын санхүүжилт: Ихэнхдээ шинээр өр тавих замаар санхүүжүүлж байна.

Ихэнх орны улс ардын аж ахуй эдийн засгаа сэргээх хөтөлбөрүүдээ шинээр өр тавих, тусгай төсөв батлах замаар санхүүжүүлж байна. Европын холбооны хамтын өрийн асуудлыг хэдийгээр зарим нэг гишүүн орнууд, гишүүн орнуудын бүлгүүд эсэргүүцэж байгаа ч европын нэгдлийг бэхжүүлэх тулгын чулууг тавихад чухал алхам болно хэмээн үнэлж байгаа. Өнөөгийн нөхцөлд эдийн засгийн аргачлалууд дундаас мөнгөний нийлүүлэлт болон төв банкнуудын үүргийг нэмэгдүүлэх зэрэг бодлогын хувилбаруудаас хүлээх хүлээлт өмнөхөөс илүү эерэг байгаа. (орчин үеийн мөнгөний онол гэдэг тодотголтойгоор) Энд нэгэн адил дэлхий дахины туршлагыг харгалзан үзэх нь ач тустай. Япон 1990-ээд оноос хойш төрийн өрийн цаасыг Японы банк худалдан авах замаар "тоон үзүүлэлтүүдээ" сулруулах бодлогоо санхүүжүүлж ирлээ. Хэдийгээр Японы өр ДНБ-нийхээ 250 хувьтай тэнцдэг ч өнөөгийн засгийн газар нь ДНБ-нийхээ 20 хувьтай тэнцэх хэмжээний эдийн

засгаа сэргээх шинэ багцуудыг батлаад байна.

Туркийн засгийн газар төрийн болон хувийн компаниудынхаа өрийн ачааллыг бууруулж ингэснээрээ хувийн секторт хөрөнгө оруулалт хийх сонирхлыг өдөөхийн тулд төв банкаараа дамжуулан зээлийн хүүг бууруулахад нөлөөлсөн. Гана улсын банк компаниудаа өр төлбөрөө цаг тухайд нь барагдуулах чадвартай байлгахын тулд бодлогын хүүг бууруулж банкнуудын нөөцийн хэмжээг зээлийн хүүд нийцүүлэн бууруулсан. Дэлхийн өмнөдийн орнууд бүгдээрээ яаран хөдлөхгүй байх бодлого баримталж олон газарт инфляц хэт өсөх, санхүүгийн системүүд хэврэгшихээс айж байна. Хөгжиж буй орнуудын эдийн засагт мөнгөний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлсний улмаас ямар эрсдэл учирч болохыг юуны өмнө Азийн хямралын туршлагаас тэд мэднэ. Уг хямралын дараагаар зүүн Азид санхүүгийн



системүүдийг тогтворжуулах бүс нутгийн механизмуудыг нэвтрүүлсэн юм. Латин Америкт нэгэн адил өрийн асуудал олны анхааралд байна. Аргентины төрд дампуурах

аюул нүүрлэсэнтэй холбоотойгоор хувийн зээлдүүлэгчидтэй өрийн бүтцийг өөрчлөх тухай хэлэлцээрийг дахин нэг удаа хийж байна.

Ирээдүйн тухай дахин ярилцъя: Прогрессив буюу өсөн нэмэгдэх татварын бодлого

Улс орнуудын төр орлогын нэмэлт эх үүсвэртэй болно гэдэг утгаараа зарим орнуудад төрөл бүрийн татварыг нэмэгдүүлэх тухай хэлэлцээр явагдаж байна. Иймэрхүү саналууд юуны өмнө үйлдвэрчний эвлэлүүд зэрэг дэвшилтэт бүлгүүдээс ирж байна. Хямралын үед тэдний дуу хоолойг уухайлан түрэгсэд ч олон байна.

- Аргентины парламентад зүүний нам цар тахлын үед нэг л удаа тушаах хөрөнгийн татвар нэвтрүүлэх тухай хуулийн төслийг танилцуулаад байна.
- Болгарт анх удаа өөр өөр чиглэлийн улс төрийн намууд хамтран албан татвар ногдуулах системийг шинэ нөхцөл байдалд нийцүүлэх, татварын нэгдсэн буюу ижил хувь хэмжээгээр татвар ногдуулдаг байсан системийг дахин сэргээх эсэх асуудлаар санал солилцож байна.
- Коста Рикад 2019 оны дундаас бараа эргэлтийн нэгэн шинэ татвар нэвтрүүлснээс болоод юуны өмнө жижиг компаниуд албан бус сектор луу шилжээд байна.
- Их Британид хямралд өртсөн зарим компаниудад хямралаас гарахад нь тусалсныхаа төлөө баячуудын олсон ашигт нэг удаа ашгийн татвар ногдуулах тухай саналыг хэлэлцэж байна. Энэ нь хөдөлмөр ба хөрөнгөөс олж буй орлогод ногдуулах татварын ачааллыг тэнцвэржүүлэх нэгэн боломж юм.

- Австрид хүн амын ихээхэн хэсэг нь хөрөнгө ба өв залгамжлалд шударга татвар ногдуулахыг шаардаж байна. Энд татвараас зугтахтай тэмцэх асуудал ч яригдаж байна.

- Польшийн засгийн газар европыг татварын бодлогыг нэгдсэн зохицуулалтад оруулж европын холбооны нутаг дэвсгэр дээр татвараас зугтахын эсрэг тэмцэхийг шаардаж байна.

- Оросод хөрөнгөлөг хүмүүст хамтын хариуцлагын тодорхой хувийг үүрүүлэхийн тулд цар тахал эхэлснээс хойш хуримтлуулсан хуримтлалын бонус тодорхой хэмжээнд хүрсэн нөхцөлд татвар ногдуулах тухай хэлэлцэж байна.

- Испанид өргөн хүрээтэй татварын шинэчлэлийн санал боловсруулж байна. Энэ шинэчлэлийн хүрээнд орлогын болон аж ахуйн нэгжийн татварыг нэмэгдүүлэх, хөрөнгө ба өв залгамжлалын татварын зохицуулалтыг сайжруулах, технологийн компаниуд ба санхүүгийн шилжүүлэг хийдэг байгууллагуудын татварын хувь хэмжээг шинэчлэн тогтоох зэрэг саналууд багтаж байна.

Европын холбооны төвшинд европ орлогын хамтын эх үүсвэртэй болох тухай шинэ хэлэлцүүлэг хүчээ авч байна. Нүүрсхүчлийн давхар ислийн ялгаруулалтын хэмжээг шинэчилсэн стандартад нийцүүлсэн компаниудад олгодог лицензийн



худалдааны орлогын зэрэгцээ Европын комисс үйлдвэрлэлийн процесст нүүрсхүчлийн давхар исэл ихээр ялгардаг бараа бүтээгдэхүүнийг гаднаас оруулахад татвар ногдуулдаг болох, хуванцар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үндэстэн дамнасан компаниудад татвар ногдуулах, дижитал нэгдсэн татвар нэвтрүүлэх санал боловсруулаад байна. Сэхээтнүүдийн хүрээнд Францын эдийн засагч эрдэмтэн Пикеттигийн дэвшүүлсэн хямралын хохирол, санхүүжилт ба бүтээн байгуулалтын зардлыг илүү дэвшилттэй төсвийн бодлого руу эргэх замаар санхүүжүүлэх тухай саналууд нь ихээхэн дэмжлэг хүлээж байна. Дундад ба Зүүн европт татварын системүүдийг хуваарилалтын бодлогын шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шинэчилснээр парадигмын шилжилттэй дүйцэх шинэ чиг хандлага тогтож магадгүй байна.

Дүгнээд хэлэхэд сүүлийн хэдэн арван жилд хэмнэлтийн буюу бүсээ чангалах бодлого хэрэгжүүлсэн орнуудад хэмнэлтийн бодлогыг цаашид үргэлжлүүлэх санал нийгмийн өргөн хүрээтэй дэмжлэг авч чадахгүй байна. Сүүлийн жилүүдэд тохиолдоод байгаа олон төрлийн хямралууд неолиберал эрин үеийн төгсгөл ирсний илэрхийлэл тул нийгмийн баримжаат төрийг бэхжүүлэх, гүнзгийрүүлэх болон нийтийн сайн сайханд чиглэсэн бодлогууд руу дахин эргэлт хийхийг шаардаж байна хэмээн ярьцгааж байна. Энэ хямралуудыг зүүнийхэн боломж болгон ашиглаж чадах эсэх, эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүдийг нийгэм - экологийн шилжилтэд тустайгаар хэрэгжүүлж чадах эсэхийг харан байж больё.



КОРОНАГИЙН ТУН II

Даяаршлын нэгэн шинэ үе эхлэв үү? Даяаршлын түүхэнд нэгэн шинэ хуудас нээгдэх үү?

Катрина Шлэгер, Ёохон Штайнхилбер нар

Ковид-19 ганцхан цохилтоор эдийн засгийн ээдрээтэй, хоорондоо сүлжилдсэн холбоосонд хэрэгдсэн эх дэлхийг маань нам зогсоож орхив. Вирус дэлхийн эдийн засгийн систем ямар хэврэг, дэлхий дахины хамтын ажиллагаа ямар эмзэг юм бэ? гэдгийг бидэнд харууллаа. Цар тахал нь дэлхийн улс орнууд хоорондын эдийн засгийн харилцан хамаарлын зэрэг хэр өндөр юм бэ? гэдгийг ил гаргаад ирлээ. Улс орнууд хилээ хааж экспортын хориг тавьж бараа бүтээгдэхүүнүүдийг хураан авлаа. Эдийн засгийн даяаршлын суурь болсон үндсэн санаанууд болох зах зээлүүдийн нэгдэл, барааны чөлөөт урсгал, секунд, дойлоор хэмжигддэг үйлдвэрлэл, мэргэжлийн өндөр ур чадвар шаардсан олон улсын хөдөлмөрийн хуваарилалт, нийлүүлэлтийн цогц сүлжээнүүд зэрэг нь хэдхэн долоо хоногийн дотор бүгд дарамтад оров. Ковид-19 тэгэхлээр даяаршлын төвшнийг бууруулж орхив уу? Энэ асуултад өнөөдөр хариулт өгөхөд хэтэрхий эрт байна. Баттай хэлэх боломжгүй л болов уу?

Олон долоо хоног үргэлжилсэн хөл хорио, өдгөө авч эхлээд байгаа хязгаарлалтыг сулруулах арга хэмжээний дараагаар цар тахал улс орнуудын нийгмийн нэгдэл ба эдийн засагт урт хугацаанд ямар үр дагавар авчрах вэ? гэдгийг хэлж мэдэхгүй, ихээхэн эргэлзээ, айдастай байна. Даяаршил цаашид хэрхэн өрнөх вэ? гэдэг асуултын хариулт ч ихээхэн эргэлзээтэй байна. Дэлхий дээр даяаршлын хойдохыг уншсан ч дахин босоод ирсэн олон удаагийн түүх бий тул болгоомжтой байхад илүүдэхгүй. 1999 онд Сеатлед болсон Дэлхийн

Худалдааны Байгууллагыг эсэргүүцсэн жагсаалын үеэр, "Ес Арван нэг" "Nine eleven" дэлгүүр болон 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаар мөн Доналд Трампын ерөнхийлөгчөөр сонгогдсоны дараагаар томоохон хямралууд болно шүү гэдэг хатуу сануулга өгсөөр байлаа. Ковид-19 тэй хамт дараагийн хямралын нэгэн шинэ эгшин эхлэх нь баталгаатай боллоо. Энэ хэмжээний хямрал даяаршлын "эмзэг дэд бүтэц"-эд хүнд сорилт болж дэлхийн дахины эдийн засгийн арга, хэвшилд тод ул мөрөө үлдээлгүйгээр өнгөрөхгүй нь ойлгомжтой боллоо.

Дэлхийн эдийн засаг бусдаас хамааралтай байхаас айх айдас гүнзгийрсэн эргэлтийн нэгэн хэврэг цэгтээ хүрээд байгаад эргэлзэх юм алга. Хөгжлийнхөө хүрсэн төвшнөөс ухрах вий гэдэг айдастай орнуудын тоо цөөн биш. Эдийн засгийн шууд нөлөөг арилгах арга хэмжээнүүд хэрэгжүүлэхийн өмнө Ковид-19 эдийн засгийн бүтцийн өөрчлөлтөд хүргэх үү? Хүргэвэл өөрчлөлт нь ямар хэлбэртэй байх вэ? гэдэг асуултад хариулах хэрэгтэй болно. Францын ерөнхийлөгч Макроны хувьд "Даяаршлын өнөөг хүртэл хөгжиж ирсэн арга хэлбэр мөчлөгийнхөө төгсгөлд ирээд байгаа нь тодорхой болоод байна. Тэгвэл дараагийн шинэ үе нь ямар байх вэ? Олон оронд даяаршлын дараагийн үе шатны талаар хэлэлцүүлэг өрнөж эхэлсэн ч цаг хугацааны хувьд эрт, эргэлзээтэй байдлаас болоод өнөөг хүртэл тодорхой бус, олон нийтийн шаардлага, өнгө аяст нийцүүлсэн байдалтай л байна.



“Даяаршлын удаашрах үе шат эхлэх үү?”

Даяаршлын амлалтууд ба зөгнөлүүд улс төрийн хэлэлцүүлэгт давамгайлж байсан цаг үе байсан бол өнөөдөр ямар заналхийлэл хүлээж байгаа талаар илүү ярьцгаах болж. Цар тахал заналхийллийн тухай яриаг улам дэвэргэх болно. Нийлүүлэлтийн сүлжээ дэндүү урт хэтэрхий цогц байна уу? Эдийн засгийн харилцан хамааралт байдал, юуны өмнө Хятадаас хамааралт байдлыг хэрхэн бууруулах вэ? Дотоодын зах зээлээ тусгаарлах, гадаадад байгаа үйлдвэрлэлээ эгүүлэн татах, дотоодын зах зээлээ хамгаалах зэрэг нь шийдэл болж чадах уу?

Мэдээж, Цар тахлын эдийн засгийн үр дагаврыг нүцгэн тоон үзүүлэлтүүд маш ойлгомжтой тооны хэлээр хэлж өгөөд байна: Олон Улсын Валютын Сан (цаашид ОУВС хэмээн товчлох) 90 жилийн өмнө тохиосон ноцтой үр дагавартай эдийн засгийн нуралтаас хойших түүхэнд анх удаа эдийн засгийн хамгийн хүнд агшилт тохиох болно хэмээн үзэж байна. Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага (цаашид ОУХБ хэмээн товчлох) 3-р сарын байдлаар дэлхий даяар нийт 3.3 тэрбум ажиллах хүчний 2.7 тэрбум нь компани нь хаагдах, эдийн засгийн цусны эргэлтийг хязгаарлах (нийлүүлэлтийн сүлжээг богиносгох) арга хэмжээнд өртөөд байна. 2020 онд 230 сая бүтэн цагийн ажлын байргүй болж болзошгүй, үүнээс болоод олон хүмүүсийн нийгмийн байдал эрс хүндэрнэ. Эхний таамаглалын ёсоор сүүлийн 30 жилийн хугацаанд анх удаагаа дэлхий дахины ядуурал дахин нэмэгдэж өнөөгийн ядуус дээр нэмэгдэж дахин хагас тэрбум хүн ядууралд өртөнө. Олон орны улс ардын аж ахуйд экспортын хэмжээ эрс буурч зарим орны экспорт бүрэн зогсох болно. Дэлхийн Худалдааны Байгууллага (цаашид ДХБ хэмээн товчлох) энэ жил дэлхийн худалдаа гуравны нэг буюу ойролцоогоор 30 гаруй хувь агших болно хэмээн таамаглаж

байна. 5-р сарын байдлаар тив хоорондын усан онгоцны ачаа тээвэрлэлтийн тавны нэг хувь нь цуцлагджээ. Агаарын тээвэр огцом буурсны улмаас агаараар тээвэрлэх ачааны тээврийн хөлс эрс нэмэгдээд байна. Мөн Ковид-19-ийн нөлөөгөөр гадаадын шууд хөрөнгө оруулалт (цаашид ГШХО хэмээн товчлох) 50 орчим хувиар буурна. Дэлхийн өмнөдийн орнуудын эдийн засагт орлогын амин чухал эх үүсвэр нь болдог гадаадад ажиллагсдын гэр бүл, эх нутаг уруугаа шилжүүлдэг мөнгөний хэмжээ тавны нэг хүртэлх хувиар буурна хэмээн Дэлхийн Банк (цаашид ДБ хэмээн товчлох) таамаглаад байна.

Эндээс даяаршил одоогоос 10 жилийн өмнө хөгжлийнхөө оргил цэгт хүрээд буурсан, 2008 оны дэлхийн санхүү, эдийн засгийн хямрал нь уг бууралтыг эхлүүлсэн гол буруутан гэж хэлэхэд буруудах зүйлгүй. Үүний нэг баталгаа нь жишээлбэл санхүүгийн хямралаас хойш дэлхийн Дотоодын Нийт Бүтээгдэхүүнд (ДНБ-нд) дэлхий дахины бараа, үйлчилгээний худалдааны эзлэх хувь буурсан. Хэдийгээр 2019 онд дэлхийн эдийн засаг тогтмол өсөлттэй байсан ч дэлхийн худалдааны нийт эзлэхүүн тэр ч байтугай буурсан. Улс орнуудын хил дамнасан санхүүгийн урсгал 2007 онд оргил цэгтээ хүрсэн ч ГШХО арван жилийн өмнөх дээд төвшиндөө дахин хүрч чадаагүй юм. Дэлхийн ДНБ-нд үндэстэн дамнасан компаниудын эзлэх хувь тогтмол буурсаар байна. Үүний зэрэгцээ өрсөлдөөнд олон үндэстний оролцоотой концернууд улс орнуудын дотоодын компаниудад ихэнхдээ ялагдаж байна. Экономист сэтгүүл шинэ эрин үеийн хөгжлийг “даяаршил удаашрах үе” хэмээн нэрлэсэн нь даяаршлын хөгжил хэдэн арван жилийн өмнөх үеийнх шиг эрчимтэй байхаа больсон, даяаршлаас айх айдас нэмэгдэх болно гэсэн санааг агуулж байгаа юм.



КОРОНАГИЙН ТУН III

Ковид-19-ын дараах хөгжлийн хандлагууд

Энэхэн цаг үед Ковид-19 өнгөрсөн арван жилд даяаршлын улмаас удааширсан хөгжлийн хандлагуудыг энэ арванд харин эсрэгээрээ хурдасгаж хөгжлийн эдгээр хандлагад

боломжит хариултуудыг өгөх шаардлагатай болох нь. Хоорондоо олон талаар холбоотой нийтдээ хөгжлийн дараах 7 хандлагууд энд онцгой ач холбогдолтой юм.

Хөгжлийн хандлага 1: Томоос том асуултын тэмдэг-Өсөлт зогссон уу?

2008 оны үед олон ажиглагчид эдийн засаг нэгэн богино хугацааны, эргүүлж болох шоконд орох нь, уг шокийн дараагаар тун удалгүй эдийн засаг эргээд сэргэх болно гэдэг хүлээлттэй байсан юм. Гэтэл өнгөрсөн арван жилд эдийн засгийн хөгжлийн динамик бүхэлдээ буурч өмнө нь хэрэглэж дадсан эдийн засгийг сэргээх жорууд төдийлөн хувь нэмэр болохгүй байгаа нь харагдсан юм. Хөгжиж буй орнууд төдийгүй “эдийн засгийн сэргэлтийн мөчлөг”-үүдийг удирдах эдийн засгийн хэрэгслүүд болон хангалттай нөөцтэй өндөр хөгжилтэй орнуудад хүртэл өсөлтийн хувь хэмжээ нь тал хувьдаа хүртэл буурсан юм. Арван жилийн өмнө дэлхийн эдийн засгийг хямралыг даван туулахад ачааны хүндийг үүрсэн, хямралын дараагийн арван жилд дэлхийн эдийн засгийн өсөлтийн гуравны хоёрыг бүрдүүлдэг, өдгөө эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа орнуудын эдийн засгийн өсөлт буурч байна. Хөгжлөөр буурай орнуудын эдийн засгийн өсөлт тогтвортой хөгжлийн зорилтоос эрс доогуур, ядуурлыг бууруулах зорилтыг хангахад шаардагдах өсөлтийн доод хэмжээ буюу 7%-д ч хүрэхгүй байна.

ОУВС үүнийг “шинэ дундаж” гэж нэрлэсэн бол Америкийн эдийн засагч Лерри Саммерс “дэлхийн зогсонги байдал”, Хятадад “шинэ нормаль буюу шинэ хэвийн байдал” хэмээн нэрлэж байна. Эдгээр ойлголтууд бүгдээрээ өсөлтийн хувь хэмжээ нь доогуур, бууралттай, хөрөнгийн орлого багатай эдийн засгийн

нэгэн шинэ мөстлөгийн үеийг тодорхойлж байна. Хүн ам зүйн хөгжил, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал, хэрэгжилтийн хүч дутмаг, инновацийн хөрөнгийн хэрэгцээ буурсан, банкнуудад итгэх итгэл сул, эсвэл төрийн хэтийдсэн өр зэрэг олон учир шалтгаануудын аль нь ч байлаа гэсэн эдийн засгийн өсөлт нь нийгмийн сайн сайхны эргэлтийн болон тулгуур цэг нь болдог улс ардын аж ахуйнууд ба хөгжлийн загваруудад сайн мэдээ биш юм.

Өнгөрсөн 30 жилд ОУВС-гийн албаны хүмүүст ойрын саруудын эдийн засгийн хөгжлийн таамгийг гаргахад ийм хэцүү үе тохиож байсангүй. Сүүлийн долоо хоногуудад ДБ ба ОУВС өсөлтийн таамгуудаа дахин нэг удаа эрс доошлууллаа. 2020 онд дэлхийн ДНБ 3 хувиар буурах таамаг байна. Харин улс орнуудын ДНБ-ний бууралт хоорондоо томоохон зөрүүтэй байх болно. 2021 онд дэлхийн эдийн засаг 5.8%-иар өснө гэдэг таамгийг ОУВС-гийн ерөнхий эдийн засагч Гита Гопинать дэвшүүлсэн бөгөөд энэ нь хэсэгчилсэн өсөлт байх болно. Зарим орон зөвхөн хямралыг гэтэлнэ, зарим орны эдийн засаг өсөлттэй алаг цоог байна. 2021 он өнгөртөл дэлхийн эдийн засаг өсөлтийн хувь хэмжээгээ нэмэгдүүлэхийн төлөө тэмцэх болно. Ирэх арван жилд цар тахлын эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх нөлөө ямар байхыг бодитойгоор таамаглахад хэтэрхий эрт байна. Өнөөдөр баталгаатай хэлж чадах нэг зүйл бол: Цар тахлаас болоод дэлхий дахины өсөлт нэмэгдэхээсээ илүү буурах нь тодорхой.



Хөгжлийн хандлага 2:

Нийлүүлэлтийн сүлжээнүүд баталгаат байдалд учирч буй нэгэн эрсдэл болох нь

Европын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага дэлхийн худалдааны 70 хувь нь дэлхийн өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн сүлжээнүүдээр дамжиж байгааг тооцоолжээ. Тээвэрлэлтийн болон харилцаа холбооны зардлын бууралт, худалдааны хязгаарлалтыг чөлөөлсний нөлөөгөөр дэлхийн эдийн засгийн сүлжээс аалзны тор мэт дэлхийг хэрэн хэрсээр эрс нэмэгдсэн юм. Саяхнаас буюу сүүлийн арван жилд цаг агаарын онц ноцтой үзэгдлүүд, улс төрийн тогтворгүй байдал, цар тахлууд, чухал ач холбогдолтой анхдагч эх үүсвэрүүдийн нийлүүлэлтийн бэрхшээлүүд зэргээс хамааран нийлүүлэлтийн сүлжээнүүдийн эсэргүүцэх чадвар ба эрсдэлийн менежментийн асуудал илүү чухал ач холбогдолтой болсоор байна.

Цар тахлын нэгэн чухал нөлөө нь ирэх жилүүдэд нийлүүлэлтийн сүлжээнүүдийн тогтвортой байдлын асуудалд засгийн газрууд болон компаниуд илүү ач холбогдол өгөх болно. Америкийн банкны санал асуулгаар судалгаанд хамрагдсан үндэстэн дамнасан компаниудын 80% нь хилийн чанадад байгаа үйлдвэрлэлийнхээ зарим хэсгийг буцаан татахаар төлөвлөж байна. Компаниуд холимог арга хэмжээнүүд авч хэрэгжүүлэх байх, эдгээрийн үр дүнд дэлхийн эдийн засгийн холбоос зарчмын хувьд буурахгүй ч өөрчлөгдөх болно.

А) Зөвхөн цөөн нэр төрлийн стратегийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нийлүүлэлтийн сүлжээг тас татах, ба дэлхийн эдийн засгаас ухрах боломж байгаа ч энэ нь маш хүндрэлтэй байх болно. Цар тахлын үеэр явагдсан эрүүл мэндийн хэрэгслүүд ба вакцин олж авахын төлөөх тэмцэл, тэдгээрийн хомстлоос үүдэн Ковид-19 засгийн газрууд ба олон улсын эмийн аж үйлдвэрүүдийг нойрноос нь

сэрээх сэрүүлэг болж тэдгээрт Энэтхэг, Хятад зэрэг цөөн тооны нийлүүлэгчдээс хамааралт байдлаа бууруулах, үйлдвэрлэлийнхээ тодорхой хувийг эгүүлэн татаж эх орондоо байрлуулах ёстой юм байна гэдгийг санууллаа. Үүний үр дагаварт эм маш үнэтэй болох болно. Энэ нь ямархуу хүндрэл авчрах вэ? гэдгийг Тиролд төвтэй Францын эм үйлдвэрлэгч Мобартис (европын сүүлчийн пенциллин үйлдвэрлэгчдийн нэг) үнийн дарамтаас болоод ирээдүйд Азиас эмээ нэмж худалдан авах болно гэдэг мэдэгдэл хийснээс харж болно. Япон улс Хятадаас үйлдвэрлэлээ буцааж татаж Японд байршуулахаар шийдээд байгаа компаниуддаа (зарим нь зүүн Өмнөд Азийн бусад орнууд руу) 1.7 тэрбум еврогийн тусламж үзүүлнэ. Франц гадаадад байгаа үйлдвэрлэлийн шугамуудаа эгүүлэн татсан компаниудад 5.5 тэрбум еврогийн татварын хөнгөлөлт үзүүлэх амлалт өгөөд байхад уг санаачилгыг компанийн эзэд, ажил олгогчид төдийлөн дэмжихгүй байна.

Б) Нийлүүлэлтийн сүлжээнүүдийг эгүүлэн татахаас илүүтэй солонгоруулах буюу зөвхөн нэг нийлүүлэгчээс хамааралт байдлыг халах, өөр өөр хувилбаруудтай байх ингэснээр зогсолтыг боломжит хамгийн бага хэмжээнд хүргэх нь илүү оновчтой шийдэл байх болно. Энд ойрын жилүүдэд юуны өмнө үйлдвэрлэлийн эцсийн шатанд Хятадаас хамааралт байдлыг бууруулахад гол анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй. Мк\Кинсэй-ийн дэлхийн хүрээлэнгийн тооцоолсноор худалдаа-хөрөнгө-технологийн урсгалаар хэмжигдсэн дэлхийн эдийн засгийн Хятадаас хамааралт байдал 2017 онд 2000 оныхоос гурав дахин нэмэгдсэн байна. Дэлхий дахинд үйлдвэрлэгдэн гарч байгаа аж үйлдвэрийн бүтээгдэхүүний гуравны нэг хүртэл хувь нь хятадын фабрикуудад үйлдвэрлэгдэж байна.



Хятадын эдийн засгаас “хамааралт байдлыг хэсэгчлэн хална” гэдэг нь нийлүүлэлтийн сүлжээнүүдийн цогц байдлыг бууруулна гэсэн үг биш. Харин ч эсрэгээрээ.

В) Нийлүүлэлтийг цаг тухайд нь хийх нь даяаршлын үндсэн үйл явцуудын нэг бөгөөд харилцаа холбоо ба мэдээлэл боловсруулалтын салбарт гарсан томоохон дэвшлүүдийн үрээр агуулахад байгаа нөөцийг шуурхай, оновчтой хуваарилах боломжтой болсон. Агуулахын нөөцтэй байх нь илүүц гэж үзэх хэмжээнд хүртэл дэлхий дахины нийлүүлэлтийн сүлжээнүүдийн баталгаат байдал хангагдсан байлаа. Харин өдгөө үр өгөөж ба баталгаат байдал хоорондын тэнцвэрийг дахин шинээр дэнсэлж үзэх хэрэгтэй болоод байна. Нөөцтэй байх нь үйлдвэрлэлийн шугамуудын баталгаат байдлыг хангаж нийлүүлэгчдийн ач холбогдол дээшлэх болно. “Цаг тухайд нь” гэдэг менежментийг зарим талаар “нөхцөл байдалд нийцүүлэх” менежментэд шилжүүлэх болно.

Г) Зайн алслалт эрсдэлийн тооцоололд илүү чухал болно. Энэ нь олон улсын эдийн засаг

дэлхийн энгээр бус харин бүс нутгуудын энгээр тархан байрших болно гэсэн үг. Хөгжлийн энэхүү хандлагыг европын өнцгөөс харахад “хямдханаар нь Хятадаас” олж авдаг загварын өсөн нэмэгдэж буй байгаль орчин ба цалингийн зардлаас болоод сонирхол татсан байдал нь буурч байна. Энд ялангуяа бүтээмж өндөртэй, сайн мэргэшсэн ажиллах хүчинтэй, дэд бүтэц сайтай дундад европын орнууд байхад заавал Хятадаас олж авах шаардлага байна уу? гэдгийг дахин бодолцож үзэх хэрэгтэй. Автоматжуулалт ба эцсийн дамжлага дээрх хөдөлмөр хэмнэсэн технологийн дэвшлүүд, усан замын тээвэрлэлтийн үнийн тогтворжилт зэрэг нь “нийлүүлэлтийн сүлжээ”-г эргүүлэн татах илүү тааламжтай нөхцөлүүдийг бүрдүүлэх болно. Мөн урьдчилсан байдлаар 2020 оны 7-р сарын 1-нд хүчин төгөлдөр болох Африкийн чөлөөт худалдааны бүсүүд (Af-CFTA) бүс нутгийн эдийн засгийн нэгдлийг бэхжүүлж африкийн орнуудын улс ардын аж ахуйнуудыг хямралаас гаргахад нэгэн чухал түлхэц болох болно. Үйлчилгээний салбарын хөдөлмөрийн хуваарилалтын сегментүүд шинэчлэгдэх нь тодорхой болчихоод байна.

Хөгжлийн хандлага 3:

Тэгш бус байдал цаашид улам нэмэгдэх болно.

Дэлхийн дахинд өнөөгийн хөгжлийн хандлагууд ба бүтцүүд нь нийгмийн тэгш бус байдал болон бусад сөрөг үр дагавруудыг улам нэмэгдүүлэх дүр зураг тодорсоор байна. Нийгмийн тэгш бус байдал хэт гүнзгийрэх нь ядууралтай хийх тэмцлийн үр дүнг бууруулж төвийг сахисан, үүрэг функцээ биелүүлэх чадамжтай бүтцүүдийг байгуулахад саад болдог. Хөрөнгийн хэт төвлөрөл нь дэлхийн эдийн засгийн хямралд өртөмхий байдлыг нэмэгдүүлдэг. Учир нь Хөрөнгө байнга өндөр ашиг эрэлхийлж байдаг учраас өндөр эрсдэлтэй хөрөнгө оруулалтын хэлбэрүүдийг

сонгоход хүрдэг. Бүх орнууд бүгдээрээ Ковид-19-д ямар нэгэн байдлаар нэрвэгдсэн. Гэхдээ бүгд ижил хэмжээгээр өртөөгүй нь, мөн бүгд ижил хэмжээнд хариу арга хэмжээ авч чадахгүй нь үнэн. Цар тахал болон даяаршил бүгдийг тэгшитгэж адилхан болгохгүй. Харин эсрэгээрээ олон оронд цар тахлаас ч өмнө байсан тэгш бус байдлыг улам гүнзгийрүүлэх болно. Олон улс оронд ядуус, шоовдорлогсод, үндэсний цөөнхөд багтдаг хүн амын бүлгүүд, эрүүл мэндийн систем ба нийгмийн суурь үйлчилгээнд хамрагддаггүй иргэд эхний ээлжид золиос болно. Катар барилгын



талбай дээр, эсвэл Иовагаас Гюүтерслоо хүртэл нядалгааны газар ажиллаж байгаа цагаач болон гадаадын ажиллах хүчнүүдэд хамгийн хүндээр тусч байгаа юм. АНУ-д өвчлөл, үхэлд хар арьстнууд хамгийн ихээр өртөж байна.

Нийгмийн байдлын хувьд хамгийн эмзэг орнуудад вирус, хямрал, зөрчилдөөн түймэр өдөөгч шиг нөлөөлдөг. Хилээ хааснаас болоод хүмүүнлэгийн болон эрүүл мэндийн үйлчилгээ хүрч чадахгүй байгаа, энхийн хэлэлцээр зогссон, хоорондоо мөргөлдөгч талууд цар тахлыг зөрчилдөөний нэгэн хэрэгсэл болгонашиглаж байгаатэргазруудад нийгмийн зөрчил улам хурцдаж ихээхэн хичээл зүтгэлийн үр дүнд аньсан өнгөрсөн үеийн хүч хэрэглэсэн зөрчилдөөнөөс үлдсэн шарх дахин сэдэрч байна. Улс орнуудын хямралыг даван туулахад шаардагдах нөөц ба мөнгө туйлын тэгш бус байна. Олон орнууд өнөөдрийн байдлаар өрийн шинэ хямралын босгон дээр ирээд байгаа бол зарим нь аль хэдийн энэ босгыг давчхаад байна. Өсөн

нэмэгдэж буй эрүүл мэндийн зардал, өдрөөс өдөрт буурч буй орлого (юуны өмнө түүхий эдийн үнийн уналт, аялал жуулчлалын зах зээлийн тэг зогсолт, гадаадад ажиллагсдын гэр бүл рүүгээ шилжүүлдэг мөнгө эрс багассан) болон хөгжиж буй буй болон эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа орнуудаас эгүүлэн татаж буй их хэмжээний хөрөнгийн урсгалаас болоод ирэх саруудад олон орны нөхцөл байдал эрс хурцдах болно.

Өнгөрсөн хэдэн арван жилд даяаршил: нэг талд технологийн үсрэнгүй хөгжил ба хангалуун амьдралын төвшинг эрс ахиулсан бол нөгөө талд тэгш бус байдлын ангальг улам гүнзгийрүүлсэн юм. Цар тахал дээрх хоёр хандлагыг хоёуланг улам гүнзгийрүүлэх нь олон талаас батлагдаад байгаа юм. Үүний зэрэгцээ бодлогын олон талбар дээр олон улсын татвар-худалдаа-санхүү-өр-хөрөнгө оруулалтын бодлогоор системчлэгдсэн нийгмийн тэгш бус байдлыг бүтцийн өөрчлөлт хийх замаар замаар бууруулах болно гэдэг ухамсар улам бэхжих болно.

Хөгжлийн хандлага 4:

Эсэргүүцлийн хөдөлгөөний шинэ арван

Дэлхийн эдийн засгийн өнөөгийн бүтэц, хэлбэрийн эсрэг чиглэсэн эсэргүүцлийн болон нийгмийн хөдөлгөөнүүдийн ач холбогдол өнгөрсөн арван жилд дахин дээшиллээ. Өлсгөлөнгийн улмаас дэгдэж буй бослого үймээн, компани, үйлдвэрлэл дээр гарч буй балмад зөрчил, хотуудад гарч буй үймээн, самуун, эдийн засгийн хэмнэлтийн хөтөлбөрүүдийн эсрэг олноороо нэгдэх зэрэг эсэргүүцлийн хөдөлгөөнүүд дэлхий дахины эдийн засгийн асуудлуудыг олны анхаарлын төвд авчирлаа. Хакерууд, зааварлагчид Панамын баримтууд зэрэг асар их багтаамжтай мэдээлэл рүү нэвтэрч компаниуд, засгийн газрууд, санхүүгийн зах зээлүүдийн актёрууд хоорондын нууц

наймааны баримтуудыг ил болголоо. Тодорхой шалтгаанууд нь өөр өөр боловч хөдөлгөөнүүдийн шаардлага нь эдийн засгийн шударга ёс, бодит ардчилал, эрхийн асуудал дээр төвлөрч ихэнхдээ эдийн засгийн шударга ёс, бодит эдийн засаг, эрхүүд рүү чиглэж байна. Ингэснээр эсэргүүцэл нийгмийн өдөр тутмын амьдралын анхдагч суурь болсон дэд бүтцийн элэгдэл, хомстол улс орнуудын нийгмийн томоохон хэсгийн хэрэгцээнээс тасарч алсарсан эдийн засгийн эсрэг чиглэж байгаа юм. Дэлхий дахинд нэн ялангуяа хотуудад үнийг нь төлж дийлэхүйц орон байр, тээвэр, эрчим хүч, хүнсний зүйл, эрүүл мэндийн үйлчилгээний төлөөх тэмцэл “нийлүүлэлтийн хомстлыг эсэргүүцэх”



тэмцлийн салшгүй хэсэг нь болоод байна.

Цар тахлын улмаас олон оронд эсэргүүцлийн хөдөлгөөн илүү эрчимжих нь тодорхой болоод байна. Дэлхийн улс орнуудын эдийн засаг хямралаас гарч чадах эсэх, хямралын хохирлыг хэн төлөхөөс олон юм шалтгаалах болно. (Эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүдийн тухай коронагийн тун I-ээс уншаарай). 2008 оны дэлхийн санхүүгийн хямралын дараагаар олон оронд хэрэгжүүлсэн бүсээ чангалах хэмнэлтийн хөтөлбөрүүд эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийн шийдвэрлэх өдөөгч нь юм. Эдийн засаг-эрүүл мэндийн хямралын өртөг зардал энэ удаад ч гэдсээ тасартал бүсээ чангалах хэмнэлтийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэхэд хүргэх болно.

Хөгжлийн хандлага 5: Төрийн сэргэн мандалт

Даяаршлын давлагаа түрж эхэлж байсан 1990-ээд оны үед саар бүхнийг төртэй нааж дэлхий дахины үйл явцуудын буруутнаар “бүгдийг залгихад бэлэн уугаачин, идээчин”-ээр төрийг тодруулж нэр хүндийг нь гутааж байлаа. Одоо шилжилтэд бэлтгэх бүтцийн орчныг идэвхтэй төвхнүүлэгч нь төр байх ёстой гэж үзэхээсээ илүүтэй хаана зах зээлүүд бүтэлгүйтэж, эсвэл бусад төрлийн хямралуудтай тэмцэх шаардлага гарна, тэнд эхний ээлжид хямралын менежер, тогтворжуулагч, хадгалагч хэмээн төрийг залж байна.

Нэгэн аравны дотор улс орнуудын төр эдийн засаг ба нийгмийн ноцтой хямралын улмаас хоёрдох удаагаа хөндлөнгөөс оролцох хэрэгтэй боллоо. Олон орныг хамарсан хямралын туршлагаас бид улс төрийн аргаар, бодлогоор шийдвэрлэж болдоггүй зүйл тун цөөхөн юм гэдгийг мэдэж авлаа.

Олон газарт цар тахлын үеэр төрийн бүтцүүд иргэдээ хамгаалах болон нийтийн сайн сайхныг бэхжүүлэхэд (эргэн) анхаарч зах зээлийн ашиг

Зардлыг санхүүжүүлэх мөнгө хомстолтой дэлхийн өмнөдийн орнууд байна уу? эсвэл зарим засгийн газрууд хямралыг неолиберал онол, хэрэгслүүдээр хямралыг дахин нэг удаа давж гарах уу? гэдгээс үл хамааран улс орнууд бүгдээрээ хэмнэлтийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх болно. Үүний зэрэгцээ энэ хямрал дэлхий дахинд суурь тэтгэвэр, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээ, анхдагч бүтээгдэхүүнүүдийн үнэд хяналт тавих, түрээсийн үнийн өсөлтийг сааруулах зэрэг арга хэмжээнүүд нэвтрүүлж нийгмийн байдлыг намжааж чадах эсэхийг харуулах болно. Нийгмийн хөдөлгөөнүүд эдгээр арга хэмжээнүүд дээр суурилан шаардлагаа тодорхойлох болно.

сонирхлыг сөрөн зогсож бодлогоо хэрэгжүүлж, нөөцийг нийгмийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хуваарилж олны хайрыг татдаг ч эдийн засгийн бодлогын үл гүйцэлдэх үзэл үнэнд гүйцэгдэв. Эндээс авсан сургамж нь: Хэрвээ улс төрчид хүсэх юм бол төр ямар ч хүнд нөхцөлд үйл ажиллагаа явуулах чадамжтай байдаг. Эндээс төрд итгэх итгэл бий болдог. 2008 оны санхүүгийн хямралын дараагаас ялгаатай нь санхүүгийн зах зээлийн харилцаануудыг зохицуулалтгүй орхисон гэж төрийн бүтцүүдийг буруутгаж байсан, дараагаар нь хэрэгжүүлсэн хэмнэлтийн хөтөлбөрүүдийн нөлөөгөөр төрд итгэх итгэл улам суларсан бол цар тахлын үеэр төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн хамрах хүрээний тухай маргаан гарах бүрт төрийн үйл ажиллагаанд итгэх итгэлийг бэхжүүлж байна. Цар тахлын дараагаар төрд итгэх итгэл яаж, хэр хэмжээнд тогтворжих болон эдийн засаг ба төр, нийгмийн хамтарсан тоглолтын харьцааны тэнцвэрийг шинэчлэн тогтооход ямар хувь нэмэр оруулах бэ? гэдгийг хэлэхэд эрт байна. (Төр ба нийтийн сайн сайхан сэдэвт коронагийн тунг уншаарай)



Хөгжлийн хандлага 6: Бүтцүүдийн сул талууд

Олон талтын оролцоотой олон байгууллагуудад ногдсон үүрэг нь хүнддэж ачаа нь хүндэдсэн тэмээ мэт аахилж уухилан зүтгэж байгаад эргэлзэх юмгүй илэрхий тул тулгараад байгаа сорилтуудыг үр өгөөжтэй даван туулах чадавхтай болгохын тулд тэдгээрийг нэн даруй шинэчлэх шаардлагатай байна. Мультилатерализм буюу олон талтын оролцоотой бүтцүүд бүхэлдээ, тэр дундаа дэлхийн эдийн засаглалын байгууллагуудын зорилтууд, үйл явцууд, бүтцүүдэд эргэлзэх зарим томоохон гишүүн орнуудын эргэлзээ нэмэгдсээр байна. Манай улс нэн тэргүүнд стратеги ба нэг талтын рефлекс, их гүрний бодлогын сэргэн мандалт, нөлөө бүхий гүрнүүд хоорондын урт хугацаанд үргэлжилсэн харилцан үл итгэлцэл ба хардлага, дэлхий нийтээрээ дагаж мөрдөх дүрэм журмуудаас хүссэнээ хэрэгжүүлэх, хүсээгүйгээ үл хэрэгсэх, нэгэнт элсэн орсон гэрээ хэлэлцээрүүдийг цуцлах, олон талтын оролцоотой чухал байгууллагуудыг үл тоомсорлох, гэрээгээр хүлээсэн санхүүжүүлэх үүргээ биелүүлэхгүй байх зэрэг нь олон талтын оролцоотой үйл ажиллагааг алаг цоог болгон тасалдуулж зарим талбар дээр хаалт тавьж байна. Дэлхийн Худалдааны Байгууллага-(ДХБ) зэрэг эдийн засгийн даяаршлын төв байгууллагуудын үйл ажиллагаа ихээхэн доголдож олон жилийн өмнөөс шинэчлэлийн зорилтууд гацаанд ороод байна.

Ковид-19 дараах хоёр хандлагыг улам тодорхой болгож байна: Нэгдүгээрт улс орнуудын үндэсний төр дангаараа шийдвэрлэж чадах асуудлууд байна. Цар тахлууд, эдийн засаг - санхүү - хөгжлийн хямралууд (жишээлбэл дэлхийн дулаарал) зэргийг үндэсний төр дангаараа шийдвэрлэж хүчрэхгүй. Улс орнуудын ихэнх нь (ядуу орнууд голдуу) хямралын эдийн засгийн

үр дагаврыг хэр хэмжээнд арилгаж чадсанаас тэдний олон улсын хамтын ажиллагааны зэрэг буюу далайц ямар байх нь шалтгаална. 2008 оны санхүүгийн хямрал, 2014 оны Эболагийн хямралаас ялгаатай нь өнөөгийн цаг үеийн хямралтай зэрэгцээд геополитикийн өрсөлдөөн (7-р хэсгийг уншаарай) хямралын дараагийн үеийн менежментийг шууд тодорхойлох болно. Ковид-19 нь дэлхийн засаглалын хуучирсан бүтцүүд арай ядан далдалж байсан дэлхийн бодлогын анархи байдлыг ил гаргаад ирлээ. Дэлхийн бодлогын анархист байдал улс үндэстнүүдийн цар тахлын нөлөөг дангаараа шийдэх гэсэн оролдлого, эрүүл мэндийн хэрэгслүүд зэргийг манай хөрш-гуйлгачин буюу хөршүүдээсээ гуйж түүх бодлого, АНУ-ын зүгээс Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага руу довтолж буй довтолгоо, Их-20 -ийн хүрээнд явагдаж буй улс орнууд юуны өмнө хөгжиж буй болон эрчимтэй хөгжлийн гараан дээрээ байгаа орнуудын өр, зээлээ цаг тухайд нь төлөх чадварыг дээшлүүлэх тухай хэлэлцүүлэг, дэлхийн аюулгүй байдлын зөвлөлийн үл ажиллагааны доголдол зэргээр илэрч байна. Өнөөдрийг хүртэл гишүүн орнууд олон удаа дипломат аргаар шийдэх оролдлого хийсэн ч дэлхий дахинд дайныг түр зогсоох, хамгийн сул, эмзэг хүмүүсээ хэрэгтэй зүйлсээр нь хангах, мөргөлдөөнтэй байгаа нутгуудад вирус тархахаас сэргийлэх арга хэмжээ авах тухай НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн даргын уриалгыг дэмжиж чадахгүй байна. Мультилатерализм нь 75 жилийн ойн дээрээ салаа замын уулзвар дээр ирээд байна: Цар тахал олон талтын үйл ажиллагааг цаашид улам доголдуулж, сулруулах уу? эсвэл хямралын үр дагавартай тэмцэхдээ олон талтын үйл ажиллагааны суурийг бэхжүүлэх үү? Хямралын үр дагаврыг арилгахдаа олон талтын суурийг бэхжүүлэх боломж бол байгаа, гэхдээ амар, хялбар бус.



Хөгжлийн хандлага 7: Шинэ гео эдийн засаг

Дэлхий үймээн самуун ихтэй байх үед ч аалзны тор шиг сүлжилдсэн дэлхийн эдийн засгийн холбоосыг найз, дайсан хоёрыг салахгүйгээр наадаг сайн цавуу гэж үздэг байлаа. Хэдэн жилийн өмнөөс АНУ, Хятад мөн Орос улс төрийн нөлөөгөө нэмэгдүүлэх тэмцлийн талбар дээр өөртөө ашигтай байдал бүрдүүлэхийн тулд торгуулийн гаалийн татвар, хориг арга хэмжээ авах, түүхий эдэд хяналт тогтоох, дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх, зээл олгох зэрэг эдийн засгийн хэрэгслүүдийн бүхэл бүтэн хуаран ажиллуулснаас болоод дэлхийн эдийн засагт хатуу уур амьсгал бүрдээд байна. Гаалийн татварыг өндөр тогтоох, экспортод хязгаарлалт тавих замаар өөрийн орны дотоодын эдийн засгаа хамгаалах нь зөвхөн нэг зөөлрүүлсэн хувилбар нь юм. Цаад зорилго нь: дэлхийн худалдаа, мэдээлэл, эрчим хүч, санхүүгийн урсгалд хяналт тавих, улс төрийн шийдвэрт нөлөөлөх явдал юм. Ямар хурдан хугацааны дотор энгийн нэг бүтээгдэхүүн стратегийн бүтээгдэхүүн болон хувирч болдгийг саяхан АНУ Германы Тювенгийн Күребас тарилгын компанийг худалдан авах гэсэн оролдлогоос харж болно. Мөн хятадын гар утас үйлдвэрлэгч Хуавей компанитай холбоотой дэгдсэн хэрүүл Хятад-Америкийн өрсөлдөөнөөс Европ болон бусад бүс нутгуудад ирээдүйд юу хүлээгдэж байгааг тодорхой харууллаа.

Ковид-19 их гүрнүүд хоорондын өрсөлдөөнийг намжаахаасаа илүүтэй түймэр мэт өдөөж байгааг болон олон орнууд аж үйлдвэрийн нийлүүлэлтийн сүлжээнийхээ Хятадаас хамааралт байдал ямар үр дагаварт хүргэж болохыг ясандаа тултал ойлгосон байж таарна. Вирусийн гарал үүсэл ба эрүүл мэндийн хэрэгслүүдийн талаар Хятад-Америкийн хооронд дэгдсэн хоёр орны хэрүүл, маргаан хэр хэмжээнд хүртэл шат ахин

хурцдах боломжтой вэ? гэдгийг харууллаа. Мөн Хятад улс худалдааны хэрүүлийг зогсоох тухай үндсэн тохиролцоонуудын нэг болох АНУ-аас хийх хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний импортыг нэмэгдүүлэх тухай "Хэлэлцээрийн 1-р үе шат"-ыг арай ядан давж байна. Хятадын гахайн аж ахуй эрхлэгсэд хамгийн хямд тэжээлийг сонгож байгаа нь Бразилын мөнгөн тэмдэгтийн ханшийг улам сулруулж байна. Хятад - Америкийн худалдааны маргаанд нэгэн шинэ хуудас нэмэгдэх бололтой. Намжихаасаа илүү шат ахин хурцдаж буй Хятад - Америкийн харьцаа дээрээс нь улам ширүүсэхээр заналхийлж буй худалдааны зөрчилдөөн, Брексит буюу Англи улс Европын холбооноос гарах зэргээс болоод цар тахал дууссан ч дэлхийн эдийн засагт найдваргүй байдлын мэдрэмжийг улам нэмэгдүүлсээр байх болно. Нөлөөллийн орон зайн сэтгэлгээ ба тусгаарлах үзэл санаа дэлхийн эдийн засагт цаашид улам бэхжиж олон орнууд "нөөц нь багасаж буй" эсвэл "амин чухал" бараа бүтээгдэхүүнд тавих хяналтаа чангаруулж хэтэрхий урт болон хэтэрхий цогц нийлүүлэлтийн сүлжээнээс хамааралт байдлаа бууруулах бодлого баримтлах болно.

Ирээдүйн зах зээл болох хятадын зах зээл дээр гарах сонирхол ба холбоотон АНУ-аа дэмжих хоёр хэцүүгийн нэгийг сонгох сонголт аль ч оронд амаргүй сонголт байх нь мэдээж. Нэн ялангуяа Европын Холбоо ба Германы хувьд хүндхэн сонголт байх болно. "Европын эдийн засгийн тусгаар тогтнол" нь европын төвшинд сэтгэл сэргээх шинэ үг бөгөөд ЕХ болон гишүүн орнууд европын эдийн засгийн олон салбаруудын хамгаалалтыг хэрхэн сайжруулах, үүний дотор эх орны үйлдвэрүүдэд төрийн тусалцаа үзүүлэх, хөрөнгө оруулалтын нэгдсэн бүртгэлтэй болох, өрсөлдөөний



бодлого, Европын олон улсад эзлэх байр суурийг дээшлүүлэх зэрэг асуудлаар хэлэлцэх шаардлагатай. Франц хэдэн жилийн өмнөөс европын аж үйлдвэр, технологийн тусгаар тогтнолыг бэхжүүлэх бодлого хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд цар тахлын үеэр энэ бодлогоо дахин нэг шинэчлээд байна. Франц улс Герман - Францын идэвх санаачилгын хүрээнд судалгааны салбарт гаргаж буй европын хичээл зүтгэлийг нэгтгэж, европын өрсөлдөөний эрх зүйг шинэчлэх, эмийн судалгаа ба үйлдвэрлэлийг европ руу эгүүлэн татах, европын байгаль орчны нормуудыг чангатгах, европын гадаад хил дээр нүүрсхүчлийн давхар ислийн ялгаруулалтад татвар ногдуулах, европын хүнсний баталгаат байдлыг хангахын тулд европын нэгдсэн хөдөө аж ахуйн бодлогын чиг хандлагыг шинэчлэн тогтоох зэрэг бодлогыг хэсэгчлэн хэрэгжүүлэх уриалга гаргаад байна. Энэ хямралаар олон компаниуд гадаадын компаниудын хямдхан олз болох хэмжээнд хүртлээ сулраад байна. Блумберг европын компаниудыг сонирхох хятадын сонирхол эрс нэмэгдэж байгааг онцлон тэмдэглэсэн юм. Энэ мэдээллийн дараагаар Испани, Итали, Франц, Герман хөрөнгө оруулалтаа хамгаалах бодлогоо чангатгасан юм.

Хөгжлийн дээрх хандлагууд даяаршил төгсгөлдөө ирснийг зарлаж байгаа юм биш гэхдээ бид ирэх жилүүдэд дэлхийн нэгдэх үйл

явцын өмнөөс илүү хязгаарлагдмал хувилбар хэрхэн хэрэгжихийг харах болно. Цар тахлын нөлөөгөөр улам хурдсаж буй хөгжлийн эдгээр хандлагуудын дийлэнх нь дэлхийн эдийн засаг болон улс орнуудын нийгмийн найдваргүй байдлыг улам нэмэгдүүлэх болно. Дэлхийн байгууллагууд ба улс орнуудын төр эдийн засгийн зохицуулалтуудыг сайжруулах талаар илүү хичээл зүтгэл гаргахгүй бол найдваргүй байдал улам нэмэгдсээр байх болно. Эрсдэлийг эрс бууруулах гэдэг үг нийлүүлэлтийн сүлжээнүүдийн шинэчлэн зохион байгуулалтад түлхүүр үг байх болно. Юуны өмнө стратегийн бараа бүтээгдэхүүний хувьд дэлхийн эдийн засгийн сүлжилдсэн хэлхээсийг бууруулах нь зөвхөн явцуу хүрээлэл дунд нэмэртэй байж болох юм. Ойрын жилүүдэд дижитал болон тоон технологийн худалдаа үйлчилгээний салбарт өндөр өсөлт гарах болно. Худалдааны урсгалууд, мэдээлэл - хөрөнгийн урсгал, үнийн байршлын давуу талууд, олон улсын хөдөлмөрийн хуваарилалт зэрэг даяаршлын олон үндсэн салбаруудад өсөлт бүр алга болохгүй. Гэхдээ нийгмийн дуу хоолой, компаниудын шинэ практик, засгийн газруудын үйл ажиллагааны шинэ хувилбаруудын нөлөөгөөр даяаршил өөрчлөгдөх болно. Коронагийн цар тахал даяаршлын төгсгөлийн замыг зурахгүй ч даяаршлын хувьсал явагдах замын тэмдэглэгээг тавих болно.



КОРОНАГИЙН ТУН IV

“Эрх чөлөө, итгэл, хардлагын онолууд”

Катрина Шлэгер, Ёохон Штайнхилбер нар

Төр сэргэн мандаж байгаа хэрнээ засгийн газруудын ар тал бага багаар сарнисаар байна.

Өнөөдрийн байдлаар коронагийн цар тахал бидний амьдарч буй энэ эрин үеийн нэгэн том сорилт болох уу? гэдэгт дүгнэлт өгөхөд арай эрт байгаа боловч цар тахлын улмаас үүссэн эрүүл мэндийн хямрал улс орнуудын төрд урьд өмнө нь төсөөлж байгаагүй том сэргэн мандалтыг авчрахын зэрэгцээ засгийн эрхийг баригчдад итгэх олны итгэлийг ч эрс бэхжүүлэх нь тодорхой боллоо. Барууны ардчилсан орнуудын төрийн өмнө “хямралын менежер нь төр л байх ёстой” гэдэг ард түмнийхээ хүлээлтийг биелүүлж, түрүүлж эрүүл мэндийн хямралд өртсөн азийн эзэрхэг төртэй орнуудаас шийдвэр гаргалт - хэрэгжүүлэлтийн чадамжаараа илүү юм гэдгээ батлах сорилт тулгарсан юм. Шинээр халдвар авагсдын тоог эрүүл мэндийн системийнхээ чадамжаас давтал хэт нэмэгдүүлэхгүй хяналтандаа байлгахын тулд барууны орнуудын засгийн газрууд хувь хүний эрх чөлөөний эрхүүдийг ихээхэн хязгаарлаж бусадтай биечлэн уулзах ба гэрээсээ гадагш гарахыг хатуу хориглож амин чухал бус эдийн засгийн секторуудыг бүхэлд нь зогсоосон юм. Эдгээр шийдвэрүүд засгийн газруудын гүйцэтгэх эрх мэдлийг нэмэгдүүлсэн төдийгүй парламентын үйл ажиллагаанд ч хязгаарлалт тогтоож олон нийтийн амьдралыг үндсэндээ нам зогсоосон юм. Барууны орнуудын нийгэм дайны дараах үеэс хойш өнөөдрийг хүртэл цар тахлын үеийнхтэй зүйрлэх хэмжээний шууд бөгөөд нийтийг хамарсан хязгаарлалтыг үзээгүй байлаа. Хямралын эхэн үед гэр гэртээ бай, гэрээсээ гарч болохгүй гэдэг нийтийг

хамарсан хөдөлгөөн хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлж эхэлж байхад европын бараг бүх оронд засгийн газраа дэмжих ард түмний дэмжлэг, итгэл маш өндөр байлаа.

Европт эрүүл мэндийн хямрал үүссэнээс хойш гурван сарын дараагаас эхлээд хориг арга хэмжээнүүдийн нийгэмд хүлээн зөвшөөрөх байдал, тэдгээрийг дэмжих ард түмний дэмжлэг суларч эхэлсэн юм. Гэхдээ улс орон бүрт харилцан адилгүй байлаа. Их 7-ийн гишүүн орнуудад хийсэн судалгаагаар судалгаанд оролцогсдын дөнгөж 48% нь өөрийн орны засгийн газрын шийдвэрийг сайшааж байлаа. (3-р сард 54% байсан бол 4-р сард 50% болж буурсан байна.) Их долоогийн гишүүн орнуудад явуулсан өөр нэгэн судалгаагаар Японоос бусад орнуудад (37% +7) 4-р сараас ард түмний дэмжлэг, засгийн газартаа итгэл хүлээлгэх байдал нь аажмаар буурч эхэлсэн. Канадад (70% /-4%), Германд 65% (-2%), Италид 65% (-6%), АНУ-д (42%-4%), Их Британид (51%/-18%) тус тус аажмаар буурчээ. Их Британийн консерватив засгийн газраас хямралын эхэн үед явуулсан барьцгүй, туйлбаргүй бодлого ихээхэн шүүмжлэл дагуулсан юм. Хожим нь гэрийн хориог дэндүү сул, нийтэд тэгш бус алаг цоог байдлаар хэрэгжүүлсэн тул ихээхэн шүүмжлэлд өртөж байлаа. Европын Холбооны гишүүн 21 оронд явуулсан дараагийн судалгаагаар: хамрагдсан орнуудын дундаас 7 орны иргэд үндэсний засгийн газрынхаа авч хэрэгжүүлсэн арга хэмжээнд сэтгэл ханамжтайгаас туйлын



сэтгэл ханамжтай (Дани, Ирланд, Португали, Нидерланд, Финланд, Австри, Грек) байна гэдэг хариултыг өгчээ. Харин Унгар, Болгар, Франц, Польш, Испани улсын иргэд эсрэгээрээ засгийн газрынхаа явуулж буй арга хэмжээнд сэтгэл гонсгор, туйлын сэтгэл хангалуун бус байна гэдэг хариултыг өгсөн.

Хязгаарлалтыг сулруулах арга хэмжээг авч эхлэхтэй зэрэгцээд маш олон оронд засгийн газрууд эрүүл мэндийн хамгаалал ба эдийн засгийн ашиг сонирхол хоорондын зохист тэнцвэрийг зөв тогтоож чадаж буй эсэх талаар хэлэлцүүлэг өрнөсөн. Туркт худалдааны төвүүд эхлээд нээгдэхэд "засгийн газар" эдийн засгийн элитүүдэд тал заслаа хэмээн шүүмжилж байлаа. Дотоодын аялал жуулчлалын салбарт засгийн газраас төлөвлөгөөт сулруулах арга хэмжээнүүдийг авч эхлэхэд Туркийн сөрөг хүчний зүгээс засгийн газарт эдийн засгийн зорилтууд бүхнээс эрхэм юм байна хэмээн шүүмжилж байлаа. Ерөнхийдөө Их Долоогийн гишүүн бүх орнуудад эдийн засгийн ашиг сонирхлыг олон нийтийн эрүүл мэндээс дээгүүр тавьж байна гэдэг бодол лавширч байна. Ийнхүү санал асуулгад хамрагдагсдын 39% нь (4-р сард 3% нэмэгдсэн) эдийн засгийн ашиг сонирхлыг нийтийн эрүүл мэндээс дээгүүр тавьж байна гэж үзсэн бол (22%+3) хувь нь эсрэгээрээ эрүүл мэнд эдийн засгийн

ашиг сонирхлоос дээгүүр тавигдаж байна хэмээн үзсэн. АНУ, Польш, Орос зэрэг зарим орнуудын засгийн газар хориог цуцлах эсвэл сулруулах арга хэмжээнүүд сонгуулийн тактикийг холбож байв. Польшид PiS намын толгойлсон засгийн газар ерөнхийлөгчийн сонгуулийн эхлэн товлосон хугацааг хэвээр нь үлдээж 5-р сарын 10-нд явуулахаар тогтов. Сөрөг хүчний томоохон эсэргүүцэлтэй тулгарсны дараагаар сонгуулийн кампанит ажил болон сонгуулийг тахал тараахгүйгээр явуулах баталгаа байхгүй тул ерөнхийлөгчийн сонгуулийг 6-р сарын 28 хүртэл хойшлуулсан. Орост Путинд дахин нэг удаа ерөнхийлөгчөөр ажиллах боломж олдож магад гэдэг найдвар тавьж байгаа тул хязгаарлалтыг сулруулах арга хэмжээнүүдийг дайн дууссаны 75 жилийн ойн цэргийн парадыг хойшлуулсан байсныг нөхөн хийх өдөр ба (6-р сарын 24-нд хийхээр төлөвлөсөн байв), үндсэн хуулийн өөрчлөлтийн талаар явуулах бүх нийтийн санал асуулга эхлүүлэх өдөртэй 7-р сарын-нд давхцуулав. АНУ-д ерөнхийлөгчийн сонгууль 11-р сард товлөгдсон саруудад цар тахлын тархалтын нөхцөл байдлаас болоод кампанит ажил нь үндсэндээ хийгдсэнгүй. Өнөө ч нөхцөл сайжраагүй, хүнд хэвээрээ байгаа хүнд хэвээрээ байгаа боловч Трамп сонгуулийн томоохон кампанит ажлуудаа хийхээр болсноо мэдэгдэв.

Иргэдийн эрх чөлөөний эрхүүдийг хязгаарласаар байгаа ч ард түмний дунд хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөр хэвээрээ байна.

Цар тахалтай тэмцэхийн тулд бараг бүх орны засгийн газрууд хүн амынхаа хөдөлгөөний эрх чөлөөг хязгаарласаар байна. Франц, Испани, Итали, Словак, Грек, Кипрт гэрээсээ гарахыг хатуу хориглох арга хэмжээ авч (зөвхөн албан байгууллагын зөвшөөрөлтэйгөөр гэрээсээ гарч болно) байгаа бол Шведэд биеэ хэрхэн авч явах, бусадтай яаж харьцах

тухай зөвлөмж өгөх хүртэл арга хэмжээ авч байна. Цар тахлын эсрэг хийж буй тэмцэл хувь хүний эрх чөлөөг хязгаарлах шийдвэрийн нийтэд хүлээн зөвшөөрөгдөх эрх зүйн үндсийг бүрдүүлж байна хэмээн европ даяар явуулсан санал асуулгад оролцогсдын гуравны хоёр нь дэмжиж байгааг европ даяар явуулсан судалгааны үр дүн харуулж



байна. Судалгаанд хамрагдсан нийт 21 оронд судалгаанд оролцогсдын талаас илүү хувь нь түр хугацаагаар хувь хүний эрхийг хязгаарлах арга хэмжээг дэмжиж байлаа. Ирланд (81%), Португали (79%), Финланд (78%) орнуудад хязгаарлалт, хорионы арга хэмжээг ард түмний хүлээн зөвшөөрөх байдал хамгийн өндөр байсан бол Словак (50%), Польш (50%), Болгар (53%), -д хамгийн бага байлаа. Хорват, Латви зэрэг орнуудад нийтийн эрүүл мэндийн төлөө цар тахлын тархалтыг бууруулахын тулд хөдөлгөөнийг хязгаарлах нь дуртай ч дургүй ч хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй арга хэмжээ хэмээн үзэж байлаа. Нийтийн ашиг сонирхлыг хувь хүний ашиг сонирхлоос дээгүүр тавьдаг Японы нийгэмд "өөрийн хариуцлага"-ын концепт нь нийгмийн хөрс суурь болтлоо төлөвшсөн байдаг. Цар тахлын үеийн нөхцөл байдлаас болоод олон нийтийн эрүүл мэнд нь хувь хүмүүсийн эрхийн хэрэгжилт ба сэтгэл санааны байдлаас дээгүүр тавигдах болсон.

Хүлээн зөвшөөрөгдөх байдал өндөр байлаа гээд үг дуугүй дагаад бай гэсэн үг биш. Хориг арга хэмжээг бүхэлд нь бус харин зарим нэг арга хэмжээг хэсэгчлэн эсэргүүцэж байна. Жишээлбэл Финландад 70-аас дээш насныхан гэрээсээ бүү гар гэдэг зөвлөмж ихээхэн шүүмжлэлтэй тулгарсан юм. Литвт

төстэй нөхцөл үүссэн нь: эрсдэлтэй бүлэгт багтдаг гэдгээр нь ресторан, хүнсний дэлгүүрүүдэд настайчуудад битгий үйлчил гэдэг журам баталсан нь настай хүмүүсийг ялгаварлан гадуурхаад байгаа юм биш үү? гэдэг хэлэлцүүлэг эрчимтэй өрнөсөн юм. Чехд нэгэн анхаарал татсан эргэлт гарсан юм. Амны хаалт зүүх нь тустай арга хэмээн эхэндээ баяртайгаар хүлээн авсан бол (энэ хооронд энэ арга хэмжээг үндсэндээ сулруулсан) хүн амынх нь зарим хэсэг амны хаалт зүүх нь дарангуйлал, эрх чөлөөгүй байдал, "коммунист хэвийн байдал" -руу эгэн очихын бэлгэдэл хэмээн эсэргүүцсэн юм. Францад хувь хүмүүсийн эрхэд халдахыг эсэргүүцэхээс илүүтэй засгийн газрын хямралын менежментэд эгдүүцэн зэвүүцэж байлаа. Бүхэлд нь дүгнэж хэлэхэд засгийн газруудын авч хэрэгжүүлсэн хориглолт, хязгаарлалтын арга хэмжээнүүдийг хүлээн зөвшөөрөх байдал өдрөөс өдөрт буурч байна. Жишээлбэл францчуудын 71% нь тэдний эрх чөлөөг урт хугацаагаар засгийн газар нь дээрэмдчих вий гэдэгт санаа зовж байна. Хориглох, хязгаарлах арга хэмжээнүүд аюулгүй байдлыг дээшлүүлдэг нь батлагдсан тул эдгээр арга хэмжээнүүд эрх чөлөөний эрхүүдийн цөм рүү халдаагүй бол хүлээн зөвшөөрч болох юм гэж үзэж байна.

Өөр өөр учир шалтгаануудын улмаас коронагийн эсэргүүцэл гарч байна.

Коронагийн цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг эсэргүүцэж буй эсэргүүцлийн хөдөлгөөн улс орон бүрт харилцан адилгүй, гарах болсон шалтгаан нь ч өөр байна. Жишээлбэл Тунист бага цалинтай секторууд эсвэл албан бус секторт ажиллагсдын нийгмийн хамгаалал сул, тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ бага учраас эсэргүүцлийн хөдөлгөөн идэвхэжсэн юм. Албан бус секторт ажиллагсдын хувьд

гэрээсээ гарахыг хориглох тухай шийдвэр тэдний амьдралынх нь суурийг дээрэмдэж орхижээ. Тэд "Өлбөрч үхсэнээс коронагаар үхсэн нь дээр" уриан дор эсэргүүцлийн хөдөлгөөнөө эхлүүлж байжээ. Унгарт ардчилал ба эрх зүйт төрийн зарчмуудыг хүчгүйдүүлсэн өндөржүүлсэн бэлэн байдлын тухай хууль эсэргүүцэл, тэмцэлтэй тулгарсан юм. Цар тахлын улмаас жагсаал цуглаан хийхийг хориглосон учраас тавдугаар сард



ерөнхий сайд Виктор Орбаны албан өргөөний цонхон доор авто машинтай жагсаал гурван удаа зохион байгуулж засгийн газрын байр суурьтай санал нийлэхгүй байгаагаа дуут дохио - сигналаа нэгэн зэрэг дуугарган илэрхийлсэн юм. Хожим нь жагсагчдыг дэндүү хатуу шийтгэсэн тул дахиад ийм хэлбэрийн тэмцэл хийх зоригтон гараагүй юм.

Хэт барууны үзлийг баримтлагч улс төрийн хүчнүүдийн зүгээс коронагаар шалтаглан тэмцэл зохион байгуулахыг олонтаа оролдсон юм. Ижил төстэй тэмцлийг Болгар, Австри, Румынд зохион байгуулсан ч олны дэмжлэг төдийлөн хүлээгээгүй юм. Нийтэд нь дүгнээд хэлэхэд хэт барууны үзлийг баримтлагч популистууд хямралын нөхцөл байдлыг далимдуулаад улс төрийн оноогоо нэмэгдүүлэх оролдлого хийсэн ч гавьтай амжилтад хүрэхгүй юм байна гэдэгтэй эвлэрэхээс өөр аргагүй болжээ. Италид Лега, Фрателли Де Итали намууд тэгэхээс тэгэх гэсэн юм шиг Ковид-19-д хамгийн их нэрвэгдсэн Ломбардей, Венето, Пиемонт бүс нутагт засгийн эрхийг барьж эрүүл мэндийн салбарын хямралын менежментийг гардан удирдаж байсан учраас байр сууриа олсон "Барууны эсэргүүцлийг санаачлагчид" хэмээн олноо үнэлэгдсэн эсэргүүцэгчид амаа үдүүлсэн мэт дуугүй суухаас өөр аргагүйд хүрсэн. Тэтгэвэртээ суусан эр Каравиниери - Генералын удирддаг "улаан шар хантаазтангууд" нэртэй нэгэн шинэ хөдөлгөөн цоргоны үүрэг

гүйцэтгэж хардлагын онолыг дэвэргэгчид ба хэт барууны үзэлтнүүдийг эгнээндээ нэгтгэж байв. Гэсэн ч олноороо шарилын газар луу тээвэрлэгдсэн нас барагсдын зураг хүмүүсийн ой тойнд дэндүү гүнзгий хадагдан үл арилах мөр үлдээсэн учраас тэд хэдхэн зуун хүнийг л хөдөлгөж чадсан юм. Францын Рассемвлемент Национал намаас 6-р сард "засгийн газрын хуурамч амлалтууд ба төөрөгдөл"-ийн хар жагсаалт бүхий ном гаргана гэж мэдэгдсэн юм. Өнөөг хүртэл тэдний "төрийн худал хуурмаг"-ийг илчлэх стратеги дэмжлэг авсангүй. Эцэст нь зөвхөн Испанид засгийн эрхийг баригч зүүний эвслийн эсрэг консерватив ба хэт барууны үзлийг баримтлагч улс төрийн намуудын эвсэл байгуулагдах бололтой. Испанийн хэт барууны үзлийг баримтлагч Вокс нам латин Америкаас үлгэр жишээ авч өөрсдийгөө "Кацероладас" хэмээн нэрлэгчдийг уриалан нэгтгэж түмпэн саваа тачигнуулан балбаж дуу чимээ ихтэй жагсаал зохион байгуулсан юм. Тэдний жагсаалд юуны өмнө Мадридын чинээлэг дүүргийн ямбатан баячууд оролцсон юм. Тэд дахин дэлгүүр хоршоогоор явж гольфын талбай дээрээ очих гэж эрх чөлөөний эрхийг нь хангахыг шаардаж байлаа. Эрх чөлөөний эрхүүдээ хангуулах шаардлагаасаа хожим нь корона руу шилжиж эрх чөлөөний эрхүүдэд тавьсан хязгаарлалтаа цуцал гэдэг шаардлагыг тавих болсон юм. Энэхүү эсэргүүцэл нь эхнээсээ засгийн газрыг хэрхэн сулруулах вэ? гэдэг тооцоон дээр явагдаж байлаа.

Өндөржүүлсэн бэлэн байдлын тухай хуулиар далимдуулж эрх мэдлээ буруугаар ашиглаж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласнаар засгийн газруудад цар тахлын тархалтыг бууруулахын тулд түргэн, нийтийг хамарсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлагатай болсонтойхолбогдуулангүйцэтгэхзасаглалын

нэмэлт эрх мэдлүүд бий болов. Ардчилал нь бэхэжсэн орнуудад урт хугацаанд коронаг ардчиллын зарчмуудыг хүчгүйдүүлэх далим болгон буруугаар ашиглахаас эхнээс нь сэргийлэхийн тулд өндөржүүлсэн бэлэн



байдлыг тодорхой хугацаатайгаар зарласан. (Жишээлбэл Финландад). Сөрөг хүчний ихэнх намууд хөдөлгөөн хязгаарлах, гэр гэртээ байх шийдвэрийг дэмжиж байлаа. Гэхдээ хязгаарлалтыг мөрдөж буй эсэхэд парламентын тогтмол хяналт тавих тухай хуульд хориг тавих зэргээр хориг, хязгаарлалтуудын тухай хуулийн төслүүдийг сулруулж байлаа. Жишээлбэл Эстонид социалдемократуудын удирдлага дор парламентад төлөөлөлтэй сөрөг хүчнүүд хямралын үед хувь хүний эрүүл мэндийн мэдээллийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд дамжуулж болох тухай хуулийн өөрчлөлтийг хүчин төгөлдөр болохоос нь өмнө зогсоож чадсан юм. Болгарт ерөнхийлөгчийн хүсэлтээр үндсэн хуулийн цэцээс эрүүл мэндийн шинэ хууль нь үндсэн хуулийн үзэл санаанд нийцэж буй эсэхийг хэлэлцэж байна. Өндөр настай, архаг өвчтэй коронагийн халдвар авсан иргэдийг эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх тухай тогтоол захиргааны хэргийн дээд шүүхийн хяналтад бүдэрч хүчингүй болов. Мөн Хорват, Латви, Словакт сөрөг хүчний намууд өндөржүүлсэн бэлэн байдлын тухай хуулийн боловсруулалтад нөлөөлж чадсан байна.

Гэсэн хэдий ч ардчилсан орнуудад эрх мэдлээ буруугаар ашигласан зарим нэгэн жишээ байна: Грект Сириза болон Социалдемократууд өндөржүүлсэн бэлэн байдлыг далимдуулан эрх зүйн тусгай актууд батлах замаар намынхаа гишүүдэд ашигтай бодлого баталж хэрэгжүүлж байна, цар тахлын эсрэг явуулж буй тэмцэлтэй хамаагүй хууль баталж байна хэмээн буруутгаж байна. Уругвайд шинээр засгийн эрхэнд гараад байгаа барууны консерватив нам “цар тахалтай тэмцэх” гэдэг нэрийн дор үндсэндээ засгийн эрхийг баригч таван намын эвслийн гэрээг хэрэгжүүлэх багц арга хэмжээнүүд баталлаа. Уг багц арга хэмжээнд эрүүгийн

хуулиас авахуулаад боловсролын бодлого хүртэл олон салбарт бодлогын шинэчлэл хийх тухай 502 зүйл заалтаас бүрдсэн, хөрөнгийн ашиг сонирхлыг хамгаалсан дарамталсан шинж агуулсан, неолиберал зорилтуудыг багтааж байна.

Эзэрхэг төрийн зүгээс хямралыг далимдуулан хэвлэлийн эрх чөлөө ба үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх рүү халдаж байгаа нь магадгүй хамгийн урт хугацаанд, хамгийн ноцтой үр дагаврыг үлдээх арга хэмжээ байж болох юм. “Хил хязгааргүй сэтгүүлчид” сэтгүүлчдийн байгууллагаас хямралын улмаас хэвлэлийн эрх чөлөөнд учирч буй дарамт ба тухайн орны дэлхийн улс орнуудын хэвлэлийн эрх чөлөөний индекс хооронд шууд хамаарал байна гэдгийг тогтоогоод байна. Хятад, Иранд коронагийн цар тахлын талаар гарч буй мэдээллийг хүртэл цензурдаж байна. Цар тахал дэгдэж эхлэнгүүт Орос хэвлэлийн эрхийг чангатгаж эхэлсэн бөгөөд одоо коронагийн талаар худал мэдээлэл тараасан бол тав хүртэл жилээр хорих аюул нүүрлээд байна. Унгарын ерөнхий сайд Орбан өндөржүүлсэн бэлэн байдлын тухай хуулиар оростой төстэй шийтгэл ногдуулахаар бэлтгэж байна. Туркт сөрөг хүчний зарим улс төрчдийн шүүмжлэлийг төрийн мэдлийн радио телевизийн зөвлөлөөр дамжуулан хаах ба хориглох арга хэмжээ авахыг оролдож байна. Мөн Филиппиний ерөнхийлөгч Дутерте хэвлэл мэдээллийн байгууллагуудад дарамт үзүүлж түүнийг шүүмжилсэн телевизийг шууд л хааж орхисон юм. Тунист засгийн газраас баталсан тогтоолуудыг шүүмжилсэн учраас сүүлийн хоёр сарын дотор олон блогчдыг баривчилж байцаагаад байна. Ардчилсан орнуудад ч хэвлэл мэдээллийн байгууллагууд ба засгийн газар хоорондын харьцаа амаргүй болж байгааг Австрийн жишээн дээр харж болно. Австрийн ерөнхий сайд



Күрц хэвлэл мэдээллийн байгууллагуудын мэдээллийн хөтөлбөрүүдэд хэсэгчлэн нөлөөлөхийг оролдож байна. Засгийн газраас “мессежинд хяналт” тавина гэж байгаа нөхцөлд шүүмжлэлтэй мэдээллийг хэр өргөн хүрээнд хийх боломжтой талаар хэлэлцүүлэг өрнөөд байна. Үүнтэй нэгэн адил Болгарт шүүмжилсэн байр суурьтай сэтгүүлчдийг шуугиан дэгдээгчид, эв санааны нэгдэлгүй, эх оронч бус хэмээн буруутгаж байна.

Мэдээллийн тахал нь хардлагын онол ба худал мэдээллүүдийн урвалж буюу катализатор нь юм.

Ковид-19 ийн тухай мэдээллийн үер савнаасаа хальж вирус, түүний эмчилгээ, вирусийн эсрэг хийх тэмцлийн стратегийн тухай шинжлэх ухааны мэдээллүүд цар тахал бусад орнуудад хэрхэн тархаж байгаа талаарх мэдээлэл худал мэдээлэл адилхан хурдацтай тархаж үнэн худлыг нь ялгаж салгахад амаргүй болоод байна. Европт явуулсан санал асуулгаар европчуудын 41% коронагийн цар тахлын тухай мэдээллийг эрдэмтдийн мэдээллээс авдаг бол 34% нь үндэсний эрүүл мэндийн байгууллагын мэдээллийг илүүд үздэг гэжээ. 32% нь дэлхийн эрүүл мэндийн байгууллагын мэдээлэлд илүү итгэдэг гэжээ. Санал асуулгад оролцогсдын зөвхөн 12% нь уламжлалт хэвлэл мэдээллийн байгууллагуудын сэтгүүлчдийн мэдээллийг итгэж болох мэдээллийн эх сурвалж гэж үздэг аж. Израильд худал, хуурамч мэдээллээс айх айдас нь олон хүмүүсийг сонгодог хэвлэл мэдээллийн хэрэгслүүд рүү дахин хандуулжээ. Учир нь цар тахлын улмаас “шинжлэх ухааны баримт нотолгоо” болон “үнэн”-ий хэрэгцээ өсөөд байна. Эзэрхэг төртэй орнуудад худал мэдээлэл, хардлагын онолыг төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд ба төрийн хяналтад

байдаг нийгмийн сүлжээний хэрэгслүүдээр зориудаар тараадаг. Филиппинд Дутертегийн засгийн газрыг шүүмжлэгчид ерөнхийлөгч худал хуурмагийг тараах явцдаа Хятадын онлайн троллеруудын армийн идэвхтэй дэмжлэгийг авч байна хэмээн хардаж байна. Оросын нэг мужийн захирагч бүс нутгийнхаа нэр хүндийг өсгөхийн тулд халдвар авагсдын тоог засварлан бууруулаад өгөөч гэдэг хүсэлт тавьсан нь олон нийтэд ил болоод байна. Унгарт цар тахлаас өмнө засгийн газарт талтай актёрууд ба байгууллагуудыг хардлагын онолын эх сурвалж гэж харддаг байсан бол цар тахлын үед ерөнхий сайд Орбаныг хардлагын онолыг түгээгч талбар нь хэмээн амандаа орсноор буруутгахад тохирох этгээд биш, учир нь тэр Хятад болон АНУ-тай сайн харилцаатай байхыг эрхэмлэдэг нэгэн.

Зарчмын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагууд ба улс төрийн мэдээллийн агуулга, байр суурьт шүүмжлэлтэй хандах нь аливаа улс орны улс төрийн соёлыг амьд, соргог байлгахад чухал үүрэгтэй байдаг. Ялангуяа иргэд нь засгийн газрынхаа хямралын менежментэд сэтгэл дундуур байгаа ардчилсан орнуудад мэдээллийн үнэн байдалд итгэх итгэл буурсан байна. Жишээлбэл францчууд, хааныхын хэний мэдээлэл вэ? гэдгээс үл хамааран мэдээлэлд эргэлзэх нийтлэг хандлагатай болжээ. Мөн Польшид албан байгууллагуудынхаа мэдээлэлд ч эргэлздэг. Нэгэн санал асуулгад оролцогсдын гуравны нэг хувь нь засгийн газар нь цар тахлын нөхцөл байдлын талаар үнэн байдлыг зориудаар нуусан гэж үзсэн байна. Энэ хардлага улс төрийн аль намын гишүүн гэдгээс үл хамааран нийтлэг ажиглагдаж байна.

Хардлагын онол, худал мэдээлэл бүх оронд байдаг. Зөвхөн тархалтын зэрэг ба ямар



бүс нутгууд болон үндэстнүүд байна гэдгээс хамаараад хачир нь л өөр байдаг. Билл Гейтс вирусийг нээсэн, эсвэл 5G сүлжээний шонгуудаас вирус тараад байна (Их Британид сүүлийн хоёр сарын дотор үүрэн сүлжээний шонгуудад 100 гаруй удаа гал тавьсан байна), вирус гэж огт байхгүй гэхээс авахуулаад вирусийн эмчилгээ хүртэл худал мэдээлэл-цуурхал тарж байна. (Францад хар тамхи сайн гэсэн бол АНУ-д ариутгалын бодисыг тариагаар хэрэглэ гэх мэт) цуурхал тараагүй газар үгүй. Ертөнцийг үзэх улс төрийн үзлээс хамаараад АНУ-д(Хятад болон бусад), Хятадад (АНУ ба Япон болон бусад) Туркт "дэлхийн еврейчүүдийн хуйвалдаан", Грек, Словакт (нууц гүрнүүд), Францад (баруун африкийн зарим орнууд) бусад орнуудыг хохироож хүн амын тоог нь хорогдуулахын тулд вирусийг бүтээсэн гэдэг цуурхал тарсан байна.

Өнөөг хүртэл Европт коронагийн хардлагын онолын тархалтыг бусад тивүүдтэй харьцуулсан судалгаа алга байна. Мөн хэвлэлийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн салбарын хувьчлал, хээл хахууль, улс төрд итгэх итгэл хоорондоо хэр харилцан хамааралтай вэ? гэдгийг судалсан судалгаа ч алга байна. Гэсэн хэдий ч европын орнуудын хардлагын онолын тухай цуу яриаг хүлээн авах байдал эрс ялгаатай гэдэг нь тодорхой болсон зүйл. Болгар, Эстон, Франц, Израиль, Хорватад бусад орнуудад өргөн тархсан цуу ярианууд нэгэн адил тархсан ч цуурхал сонсоод баярлаад байгаа юм ажиглагдахгүй байна. Латви, Литв зэрэг орнуудад иймэрхүү цуурхал тардаггүй. Учир нь эдгээр орнууд оросын санаатайгаар тараадаг хуурамч мэдээллийн кампанид сэхээ авах чөлөөгүй дарагдаж байдаг тул иймэрхүү мэдээлэлд дасаж дөжирчихсөн байдаг. Орост эсрэгээрээ Москвагийн эдийн засгийн дээд сургуулиас явуулсан судалгаагаар

хүн амын ойролцоогоор гуравны нэг хувь нь коронагийн цар тахал бол санаанаас зохиосон зүйл эсвэл гэмхоргүй гэдэг бодолтой байгааг тогтоожээ. Польшид хийсэн нэгэн судалгаагаар хардлагын онолд итгэгчдийн тоо цар тахлын улмаас эрс нэмэгдээгүй, харин цаашид ч стандарт төвшинд буюу хардлагын онолын сэдвээс хамаараад олон нийтийн 10-25%-д хэлбэлзсэн хэвээрээ үлдэх нь гэдгийг тогтоожээ. Олон нийтийн (25% Ковид-19)-ыг нээсэн буюу лабораторид бүтээсэн, хөгшид ба сул биетнүүдийг нөгөө ертөнц рүү буцаахын тулд нээсэн, 15% нь АНУ-ыг сулруулахын тулд Хятад нээсэн, мөн 15% нь Хятадыг сулруулахын тулд АНУ нээсэн гэдэг бодолтой байна. Их Британид Оксфордын их сургуулийн судалгаагаар судалгаанд оролцогсдын 21% нь вирус бол заль мэх, 62% нь хүний гараар бүтээгдсэн гэдэгт тодорхой хэмжээгээр итгэж байна. Африкийн олон оронд өдөр тутмын сонинууд, эсвэл бусад хэлбэрийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд телевиз, радиогоор нэвтрүүлдэг олон нийтийн хэлэлцүүлэг гэж бараг байдаггүй. Баруун Африкт бол хардлагын онолыг тэр дор нь шүүрч аваад цуу яриа дорхноо л улс орон даяар тарчихдаг. Эдгээр орнуудын хамгийн дуртай цуурхал нь "Франц африкийн орнуудыг хуулийн асрамжид байлгахын тулд юу гэгчийг хийж байгаа тухай цуурхал" юм. Малид нэгэн адил хардлагын онол үржил шимт хөрсөнд суулгасан үр мэт соёолж What's app группууд дамжуулсаар тэр дорхноо тардаг.



Хуурамч мэдээлэл ба хардлагын онолын эсрэг хэрэглэдэг бүгдийг анагаагч эм гэж байхгүй.

Улс орнуудын нийгэм хуурамч мэдээллийг хүлээн авах байдлаараа хоорондоо өөр өөр байдгийн нэгэн адил хэвлэл, мэдээлэл, улс төрд итгэх итгэлийг дахин яаж бэхжүүлэх вэ? гэдэг асуултад нэгдсэн хариулт өгч чадах үр ашигтай жор гэж байхгүй. Нэгэнт алдагдсан итгэлийг дахин сэргээх нь хүч шаардсан тэмцэл байдаг. Худал мэдээлэл, хардлагын онолыг няцаах олон улсад хэрэглэгддэг нийтлэг стратеги бол бий. Баруун Африкийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн ихэнх нь “хуурамч мэдээлэл” сэдвийг хөндөж уншигчид, үзэгчдээ хуурамч мэдээллийг үнэн зөв, нягтлагдсан, цэвэр мэдээллийг хуурамч мэдээллээс ялгах чадвартай болгохын тулд үндсэндээ соён гэгээрүүлэх кампанит ажил өрнүүлж байна. Мөн Франц, Австри, Эстонид хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, эсвэл төрийн байгууллагуудаар дамжуулан буруу мэдээлэлд няцаалт өгөхийг оролдсоор байна. Францын засгийн газрын зүгээс мэдээллийг нягтлаад баталгаатай гэж үзсэн сонины нийтлэлүүдийг засгийн газрын албан ёсны хомпейж дээрээ тавих арга хэмжээ авсан нь хатуу шүүмжлэлтэй тулгарсан юм. Барууны чиглэлийн улс төрийн хүчнүүдийн зүгээс засгийн газрын энэ алхмыг “үнэнийг тогтоогч яам байгуулах” эхний алхам гээд хааж орхив. Дээрээс нь бүх хэвлэлүүд засгийн газрын энэ санаачилгыг уншигчдад юу унших, юуг эс уншихыг заах гэсэн явуургүй оролдлого гэж үзэв.

Хуурамч мэдээллийн эсрэг явуулах тэмцэлд сүлжээний олон идэвхтнүүд, блогчид, онлайн порталууд хүч нэмж улс төрчдийн хэлсэн үг, нийгмийн сүлжээнд тарсан мэдээллүүдийн баримт нотолгоог гаргаж тавив. Твиттер энэ хооронд хэрэглэгчиддээ зориулан буруу мэдээллүүдийг тэмдэглэдэг, ноцтой мэдээлэл тараасан бол фрофайлыг хаах хүртэл арга

хэмжээ авч байгаа бол фэйсбук твиттертэй харьцуулахад илүү зөөлөн арга хэмжээг авч байгаа тул энд худал мэдээлэл ба хардлагын онолууд фэйсбукын группуудээр урьдын адил бөөн бөөнөөрөө тарсаар байна. Нийгмийн сүлжээнд худал мэдээлэл эрс нэмэгдсэн учраас Европын комиссын зүгээс жил тутам нийтлэгддэг ил тод байдлын илтгэлдээ нийгмийн сүлжээнүүд худал мэдээлэл тарсан нөхцөлд авах арга хэмжээ, тохиолдлын тоо зэргийг жилдээ нэг удаа тайлагнадаг байсан бол одоо сар бүр тайлагна гэдэг үүрэг өгсөн. Дээрээс нь нэмээд хэлэхэд европын комисс нийгмийн сүлжээтэй харьцах харьцааг илүү чангатгаж хэрэглэгчид нь сайн дураараа мөрддөг байсан харьцааны кодыг хуульчлан дагаж заавал дагаж мөрдөх код буюу дүрэм болгон өөрчлөх гэж байна. Европын комисс энэ оны 4-р улиралд багтаан дижитал албаны тухай багц хууль батлуулж жишээлбэл онлайн - платформуудын хуурамч мэдээлэлтэй харьцахдаа баримтлах харьцааны код - буюу журмыг хуульчлах юм байна. Вебсайтуудыг хаах нь сөрөг талуудыг авчирч болзошгүй юм. Жишээлбэл Румыны албан газрууд арван хоёр вебсайтыг хаасан боловч тун удалгүй өөр төстэй нэрээр дахин нээгдсэн бол хандалт нь өмнөхөөс таваас зургаа дахин нэмэгдсэн байна. Крымийг нэгтгэх үеэр байгуулагдсан Европын холбооны нутаг дэвсгэрээс гадуур ажилладаг хүчнүүдийн статусыг санаатайгаар тарааж буй хуурамч мэдээллийг ажиглах, баримтжуулах үүрэгтэй нэгжүүд болгон доошлуулаад байна. Эдгээр нэгжүүд нь оросын болон сүүлдээ ихэвчлэн хятадын актёруудын зүгээс олон нийтийн санаа бодолд нөлөөлөхийн тулд хэрхэмжээнд худал мэдээлэл тарааж байна гэдгийг судалдаг. Шинээр тарж буй мэдээллийн үерт хөл алдахгүйн тулд Жозеф Боррелл санаатайгаар тарааж буй хуурамч мэдээллийн



эсрэг явуулах тэмцлийг эрчимжүүлэхийн тулд санхүүгийн дэмжлэгээ нэмэгдүүлэхийг гишүүн орнуудаас шаардсан. Швед улс хэт барууны үзлийг баримтлагсад, гадаадын мэдээллийн кампанит ажлын дайралтад байсхийгээд өртөх болсонтой холбогдуулан тус улсын социалдемократ засгийн газар энэ дайралтаас хамгаалахын тулд “Шведийн

сэтгэл зүйн хамгаалал” нэртэй шинэ агентлаг байгуулах шийдвэр гаргаад байна. Зорилго нь: Шведийн нээлттэй, ардчилсан нийгэм ба Шведийн тусгаар тогтнолыг бэхжүүлэх. Шинэ агентлаг нь хуурамч мэдээлэл зориудаар тараах кампанит ажлуудыг илчлэх, тэдгээртэй тэмцэх төрийн чадамжийг дээшлүүлэх үүрэгтэй юм байна.

1925 онд байгуулагдсан Фридрих-Эбертийн сан нь Германы хамгийн ууган уламжлалт улс төрийн сан юм. Манай сан Германы эзэнт улсын анхны ардчилсан ерөнхийлөгч Фридрих Эбертийн гэрээслэлийн дагуу байгуулагдаж түүний нэрээр нэрлэгдсэн. Фридрих-Эбертийн сангийн улс төрийн өв, гүйцэтгэж буй үүрэг нь түүний үзэл санаа, гэрээслэлээс эхтэй.



Фридрих-Эбертийн сан

Ландмарк төв

Сүхбаатар дүүрэг 1-р хороо

Чингисийн өргөн чөлөө 13

Шуудангийн хайрцаг 831

14251 Улаанбаатар

Монгол Улс

Фэйсбүүк: [@fesmongolia](#)

Цахим шуудан: info@fes-mongolia.org

Цахим хуудас: <https://www.fes-mongolia.org/>

